



**УВС АЙМГИЙН УЛААНГОМ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗӨВЛӨМЖ**

CONTRACT NO. УВАОНӨГ/202105058

АГУУЛГА

1	Үндэслэл	5
2	ХОГ ХАЯГДЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ	6
2.1	ХОГ ХАЯГДЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН	6
2.1	ҮҮСЭЖ БУЙ ХАЯГДЛЫН ТӨРӨЛ	8
2.2	ХОГ ХАЯГДЛЫН ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	11
2.3	ХОГ ЦУГЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	14
2.4	ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ҮҮСЭХ ХЭМЖЭЭ.....	21
2.5	ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАН ЯЛГАЖ БУЙ НӨХЦӨЛ	25
2.6	ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	27
2.7	УЛААНГОМ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД 29	
2.8	ХОГ ХАЯГДЛААС ҮҮСЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛ, НӨЛӨӨЛӨЛ.....	30
2.9	ОДООГИЙН МӨНГӨНИЙ УРСГАЛ, САНХҮҮЖИЛТ	37
3	ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	38
3.1	ЗОРИЛТУУД	38
4	СТРАТЕГИ.....	40
5	ТӨЛӨВЛӨГӨӨ.....	44
5.1	БАРИМТЛАХ ЗАРЧИМ	44
5.2	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	44
5.3	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	46
6	ЗУРГАА. САНХҮҮЖИЛТ	51
7	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ.....	52
7.1	ЭХ ҮҮСВЭР ДЭЭР ЯЛГАН АНГИЛАХ	52
7.2	ХОГ ХАЯГДЛЫН ТЭЭВЭРЛЭЛТ.....	56
7.2.3	ДАХИВАР ХАЯГДЛЫН ТӨВ	57
7.3	ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГ	61
7.4	ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ НЬ.....	63

Зураг 3. 2020 оны 1-12 дугаар саруудын гэр хорооллын өрхийн тээвэрлэсэн нийт рейсийн тоо	11
Зураг 4. Хог хаягдал тээвэрлэлтийн явц	11
Зураг 5. 2020 оны 1-12-р сарын орон сууц хороолол болон ААН-ийн хог хаягдлыг тээвэрлэсэн нийт рейсийн тоо	12
Зураг 6. Орон сууц хороолол, ААН хог хаягдал тээвэрлэлтийн явц.....	12
Зураг 7. 2019 онд тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ.....	12
Зураг 8. Улаангом сумын иргэдийн санал.....	13
Зураг 9. Улаангом сумын хог тээврийн хөдлөх бүрэлдэхүүн.....	20
Зураг 10. Сууцын төрлөөс хамаарсан нэг хүнээс үүсгэх хог хаягдлын хэмжээ /гр/.....	21
Зураг 11. Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаас үүсэж буй хог хаягдлын хэмжээ.....	22
Зураг 12. Улаангом сумын нэг иргэнээс үүсэх хог хаягдлын хэмжээ /гр/	23
Зураг 13. Улаангом сумын нэг өрхөөс жилд үүсэх хог хаягдлын хэмжээ /кг/	23
Зураг 14. “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ хог хаягдал тээвэрлэсэн 2020 оны тайланг харьцуулж тооцвол жилд үүсэх хог хаягдлын хэмжээ /тонн/	24
Зураг 15. Хог хаягдлын бүтцийн судалгааг Улаангом сумын нийт өрхийн тоо мэдээтэй харьцуулж тооцвол жилд үүсэх хог хаягдлын хэмжээ /тонн/	24
Зураг 16. Увс аймагт хүлээлгэн өгсөн дахивар хаягдал бутлах төхөөрөмж.....	25
Зураг 17. Увс аймагт хүлээлгэн өгсөн дахивар хаягдлын овор хэмжээг бууруулах нягтруулагч төхөөрөмж	26
Зураг 18 Хог хаягдлын төвлөрсөн цэг	27
Зураг 19. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил	30
Зураг 20. Хөрсний дээж авалт	31
Зураг 21. Улаангом орчмын хөрсний хэв шинж.....	32
Зураг 22. Хөрсөн дэхь Кадмийн агууламж мг/кг	33
Зураг 23. Хөрсөнд агуулагдах хар тугалганы хэмжээ мг/кг.....	33
Зураг 24. Хөрсөнд агуулагдах хүнцэлийн агууламж мг/кг	34
Зураг 25. Хөрсөнд агуулагдах хромын хэмжээ мг/кг.....	34
Зураг 26. Хөрсөнд агуулагдах цайрын агууламж мг/кг	35
Зураг 27. Хөрсөнд агуулагдах зэсийн агууламж мг/кг.....	35
Зураг 28. Хөрсний шинжилгээгээр хийгдсэн нийт үзүүлэлтэд.....	36
Зураг 29. Гэр хорооллын айл өрхүүдийн хог хаягдлаа ангилан ялгах хогийн савны жишиг	53
Зураг 31. Орон сууц хорооллын гадна байрлан ангиллын савны жишиг зураг	54
Зураг 32. Албан байгууллага, нийтийн эзэмжлийн талбайд байршуулах савны загвар	55
Зураг 33. Нийтийн эзэмшлийн талбай, байршуулах хуванцар, лааз хийх зориулалт бүхий савны загвар ..	55
Зураг 34 Дахивар цэгийн жишиг	59
Зураг 35. Увс аймагт хүлээлгэн өгсөн дахивар хаягдал бутлах, пресслэх төхөөрөмж	59
Зураг 36 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн ерөнхий байдал.	62

1 ҮНДЭСЛЭЛ

Сүүлийн жилүүдэд Монгол орны хэмжээнд хүрээлэн буй орчны бохирдол тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа бөгөөд Улаанбаатар хот болон бусад томоохон хот суурин газар, уул уурхайн бүс нутгуудад хог хаягдлаас шалтгаалсан орчны бохирдол, доройтол ихсэх хандлага улам бүр тод ажиглагдаж байна.

Мөн судлаачдын үзсэнээр дээрх хог хаягдлын 50%-ийг бид дахин боловсруулах боломжтой хог хаягдал эзэлдэг ба өнөөгийн байдлаар хөдөө орон нутагт дахивар хог хаягдлын нөөц хэмжээ түүн дээр тулгуурласан эдийн засгийн эргэлт явагдахгүй эсрэгээрээ байгаль орчныг доройтуулах үндсэн хүчин зүйлүүдийн нэг болоод байна.

Хог хаагдлын үндэсний хөтөлбөр, Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт, Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.4.1-т бодит салбарууд, орон нутгийн засаг захиргаанд хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх гэж заасан.

Увс аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.3-т Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хог ангилах, дахин боловсруулах үүсгэл санаачилгыг дэмжинэ гэсэн заалтыг үндэслэн Улаангом сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах зайлшгүй шаардлагатай.

- Увс аймгийн Улаангом суманд хийгдсэн хог хаягдлын судалгаа
- Улаанбаатар хотод хэрэгжүүлж буй хог хаягдлын менежмент, ОУ-ын хог хаягдлын туршлага
- Увс аймгийн ИТХ-аар хэлэлцэгдэж байгаа Энгийн Хог хаягдлын тухай журам
- Одоогийн Улаангом сумд үүсээд байгаа хог хаягдлын тулгамдсан асуудлууд зэргийг үндэслэн бид энэхүү төлөвлөгөө, зөвлөмжийг гаргаж байна.

2 ХОГ ХАЯГДЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол улсад сүүлийн жилүүдэд төв суурин газрын хог хаягдлын хэмжээ өсөн нэмэгдсээр байна. Улсын хэмжээнд 2018 онд зөвшөөрөгдсөн 390 хог хаягдлын төвлөрсөн цэгт нийт 3,353,548.73 тонн хог хаягдал тээвэрлэн зайлуулжээ. Жил ирэх тусам энэ тоо нэмэгдэж байна.

2018 оны байдлаар төвлөрсөн хогийн цэгт хүргэж, дарж булж буй нийт хог хаягдлын 41.6% буюу 1,393,753 тн нь Улаанбаатар хотод үүссэн бол үлдсэн 58.4% буюу 1,959,795 тн хог хаягдал нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн байна. Үүнээс үзвэл Монгол орноос үүсэж буй хог хаягдлын дийлэнх хувийг хөдөө орон нутгаас үүссэн хог хаягдал эзэлж байна. Иймд орон нутагт хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

2020 оны байдлаар Увс аймгийн Улаангом сумын 10 багийн 6700 айл өрхийн хогийг хуваарийн дагуу ачиж нийт 1671 машин буюу 21135м3 хогийг хогны нэгдсэн цэгт буулгасан.

2.1 ХОГ ХАЯГДЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Сүүлийн жилүүдэд төр засгаас хог хаягдлын менежменттэйгээр холбоотойгоор тодорхой үйл ажиллагаануудыг зохион байгуулж байна. Ялангуяа агаарын бохирдол, хөрсний бохирдлоор зарим дорвитой арга хэмжээнүүд авч байгаа юм. Үүнийгээ дагалдаач энэ чиглэлийн бизнесийн хууль эрхзүйн орчин сайжирч байна. Үүний нэг ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ шинэчлэгдэн батлагдаж, түүний АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ дээр дагаж мөрдөх журам гарсан.

2.1.1 ХОГ ХАЯГДАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ – ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛЛАГААР 2017.05.12 –НЫ ХУРЛААР БАТЛАГДСАН.

Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Шинэчилсэн найруулгаар 2012 онд батлагдсан Хог хаягдлын тухай хуульд хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих, эдийн засгийн хөшүүрэг, урамшуулал олгох харилцааг тодорхой зохицуулаагүй, хог хаягдалтай холбоотой үйл ажиллагаанд тавигдах шаардлага тодорхой бус, аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулалт хангалтгүй, иргэдэд хог хаягдлын боловсрол олгох талаар огт тусгагдаагүй, хууль тогтоомж зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүлээлгэх хариуцлага сул, зөрчлийг илрүүлсэн иргэнийг урамшуулах зохицуулалт байхгүй зэрэг дутагдалтай талууд байсныг шинэчилсэн найруулгын төслөөр зохицуулж өгсөн. Мөн аюултай хог хаягдлын үйлдвэр байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тогтоолыг Засгийн газраар батлуулсан.

2.1.2 ХОЛБОГДОХ ЖУРАМ

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ, ЭКСПОРТЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Энэхүү журмаар аюултай хог хаягдалтай хамааралтай ажиллах байгууллагыг зөвшөөрөл олгох мөн хэрхэн хуулийн хүрээнд ажиллахын хуульчлан зааж өгсөн байгаа.

ХОГ ХАЯГДЛЫН УЛСЫН ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

Энэхүү журмын зорилго нь хог хаягдлын тоо бүртгэлийг хөтөлж, нэгтгэн боловсруулах, тайлагнах, албан ёсны статистик мэдээллийг бүрдүүлэхтэй холбогдсон төрийн захиргаа, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны журам

Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага болон хог хаягдал булах, устгах ажил эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд энэхүү журмыг удирдлага болгоно.

ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, БУЛАХ, УСТГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Энэхүү журмын зорилго нь хог хаягдал гаргах, цуглуулах, тээвэрлэх, булах иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, санхүүжүүлэх харилцааг зохицуулахад оршино.

2.1.3 ХОЛБОГДОХ ХӨТӨЛБӨР

“Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр”

Нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээ, технологийг дэмжин хаягдлыг бууруулж, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хатуу хог хаягдлын зохистой менежментийг төлөвшүүлж, цэвэр эрүүл орчин бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр

2.1.4 ХОЛБОГДОХ СТАНДАРТ

Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344 : 2011

Энэхүү стандартын зорилго нь ахуйн зориулалттай задгай хог хаягдал тээвэрлэхэд тавих шаардлагыг тодорхойлох, хяналт тавих, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулан арилгах, зориулалтын тээврийн хэрэгслийн ашиглалтыг сайжруулахтай холбогдсон ажил, үйлчилгээг зохицуулахад оршино

2.1 ҮҮСЭЖ БУЙ ХАЯГДЛЫН ТӨРӨЛ



Тус менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Улаангом сумын айл өрхүүд болон албан байгууллагуудаас түүвэр байдлаар хог хаягдлын дээжийг 10 хоногийн хугацаанд тогтмол цуглуулан хог хаягдлын бүтцийн судалгааг явуулсан. Энэхүү судалгаанд үүсэж буй хог хаягдлын хэмжээг 14 нэр төрөлд авч үзэн судалсан бөгөөд айл өрхүүд болон албан байгууллагуудын хэмжээнд нарийвчлан судалсан судалгааг судалгааны материалаас танилцана уу. Энэ хэсэгт Улаангом сумын хэмжээнд үүсэх хог хаягдлыг багцлан дараах нэр төрлийн хог хаягдлууд үүсэж байна.

1. Хатуу хаягдал
2. Барилга болон засварын хаягдал
3. Хүнсний хаягдал
4. Аюултай болон үйлдвэрлэлийн хаягдал
5. Үнс
6. Бусад хаягдал

2.1.1 ХАТУУ ХАЯГДАЛ

Айл өрхүүдээс ихэвчлэн энэ төрлийн хаягдлууд гардаг. Энд өдөр бүр бидний хэрэглээд хаягдаж байгаа зүйлс орно. Жишээлбэл : хөнгөн цагаан лааз, шилэн болон хуванцар лонх болон савнууд, гялгар уутнууд, цаасан хаягдлууд болон цаасан хайрцаг зэрэг хаягдлууд багтдаг.

Улаангом сумын дараах хэсгүүдээс хатуу хаягдлууд ихэвчлэн гардаг.

1. Айл өрхүүд
2. Албан байгууллага
3. Хотын захын малчид
4. Жижиг үйлдвэр эрхлэгчид
5. Нийтийн эзэмшлийн талбай



2.1.2 БАРИЛГА БОЛОН ЗАСВАРЫН ХАЯГДАЛ



Өөр нэг голлох хаягдал бол барилга болон засвараас үүсэх хаягдал. Энэ хаягдал нь газар ухах, тэгшлэх болон барилга угсралт, буулгалт зэргээс үүсдэг. Энэ төрөлд бетон, мод, төмөр, шороо, тоосго, чулуу, элс, дээврийн материал зэрэг маш олон зүйлийн хатуу хаягдлууд багтдаг.

2.1.3 ХҮНСНИЙ ХАЯГДАЛ

Мэдээж айл өрхүүдээс маш олон төрлийн био хаягдал үүсгэдэг. Хоолны үлдэгдэл, хоол хийх явцад их хэмжээгээр үүсэж хүнсний хаягдал болон үлддэг. Зарим тохиолдол хотын ногоон байгууламжийн арчилгаа засварын үйл явцаас мод, бут, сөөг, зүлэг зэрэг био хаягдал үүснэ. Энэ төрлийн органик хаягдлаар бордоо хийх боломжтой боловч одоогоор Монгол улсад био хаягдлаас бордоо үйлдвэрлэдэг дахин боловсруулах үйлдвэрлэл байхгүй байна. Гэхдээ үүнийг өрхийн хэмжээнд гар аргаар хийх бүрэн боломжтой. Мөн Улаангом суманд 3 мах боловсруулах үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг ба үүнтэй холбоотойгоор үүсэх малын сэвс, яс зэрэг органик хаягдлууд багтана.



2.1.4 АЮУЛТАЙ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХАЯГДАЛ



Энэ төрлийн хаягдлууд нь төрөл бүрийн тос, цэвэрлэгээний бодис болон ахуйн хэрэгцээнд ашиглагдаж буй цахилгаан хэрэгслүүд /компьютер, телевизор/ жижиг зай хураагуур зэрэг олон төрлийн хаягдлууд багтана. Мөн бусад төрлийн химийн бодисууд, тоног төхөөрөмжүүдийн үйлчилгээ болон, цэвэрлэгээ, шатахууны үйл ажиллагаа болон машин тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үйлчилгээ, засварын үед гардаг тос тослох материалууд. Энэ төрлийн хаягдал нь орчныг их хэмжээгээр бохирдуулдаг тул энгийн хаягдлаас тусад нь онцгойгоор зайлуулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

2.1.5 ҮНС



Гэр хорооллын өрхүүдийн галлагаа болон жижиг, том станцуудын галлагаанд ашиглагдаж буй мод, нүүрснээс гарч буй бүх төрлийн үнс багтана.

Үүсэх гол эх үүсвэр нь гэр хорооллын галлагаанаас үүссэн үнс болон цахилгаан, дулааны станцуудаас үүснэ. Мөн жижиг уурын зуухнууд багтана.

Улаангом сумын хувьд өрхүүдийн дунд хийсэн хог хаягдлын бүтцийн судалгаанаас харахад зуны улиралд нийт үүсэж буй хог хаягдлын 17.9%-ийг үнс дангаараа эзэлж байсан ба иргэдийн дунд өвлийн улиралд үүсэх нийт хог хаягдлын хэдэн хувийг үнс эзэлдэг вэ гэхэд 70-80% гэж хариулсан.

Дунджаар Улаангом сумын гэр хорооллын нэг өрх жилд 6тонн нүүрс 3м^3 мод түлдэг гэсэн асуумж судалгааны дүн байна.


2.2 ХОГ ХАЯГДЛЫН ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаангом нь Увс аймгийн төв юм. Увс нуурын хотгорын баруун урд захад, Хархираа уулын бэлд оршдог. Мөн ОХУ-ын хилийн ойролцоо оршдог. Газар нутаг нь 39 км² бөгөөд Улаанбаатараас 1456 км зайтай газарт оршино.



Улаангом нь Монгол улсын хамгийн нам цэгүүдийн нэг болох д.т.д 939 м өндөрт оршино. Хүн амын хувьд 2020 оны байдлаар 32,407 хүн тоологдсон байна.

Улаангом сумын хог хаягдлын тээвэрлэлт, цэвэрлэгээний ажлыг “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ хариуцан ажиллаж айл өрх албан байгууллагуудаас үүсэж буй хог хаягдлыг хогны нэгдсэн цэгт тээвэрлэн ажилладаг. Тус байгууллагын хог тээвэрлэлтийн тайлангаас харвал 2020 оны 1-12 сарын байдлаар Улаангом сумын 10 багийн 6700 айл өрхийн хогийг хуваарийн дагуу ачиж нийт 1671 машин буюу 21135м³ хогийг хогны нэгдсэн цэгт буулгасан. /Зураг1, 2/.




Зураг 1. 2020 оны 1-12 дугаар саруудын гэр хорооллын өрхийн тээвэрлэсэн нийт рейсийн тоо



Зураг 2. Хог хаягдал тээвэрлэлтийн явц

Мөн 85 нийтийн орон сууцны 1450 өрх болон гэрээт 67 байгууллага аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг хуваарийн дагуу ачиж нийт 1429 машин буюу 5000м3 хогийг хогийн нэгдсэн цэгт буулгасан байна.




Зураг 3. 2020 оны 1-12-р сарын орон сууц хороолол болон ААН-ийн хог хаягдлыг тээвэрлэсэн нийт рейсийн тоо




Зураг 4. Орон сууц хороолол, ААН хог хаягдал тээвэрлэлтийн явц

Дээрх мэдээнээс харван 2020 онд “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ нь нийт хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагааны хүрээнд гэр хорооллын 10 байрын 6700 айл өрх, орон сууц хорооллын 1450 өрх, гэрээт 67 ААН байгууллагуудаас

“Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ нь 2019 оноос эхлэн нийт Улаангом сумын хог хаягдлын тээврийг хариуцаж эхлэн ба үүнтэй холбоотойгоор тус оноос хойших тээвэрлэсэн хог хаягдлын мэдээ боловсруулагдсан байна.



Зураг 5. 2019 онд тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ



Зураг 6. Улаангом сумын иргэдийн санал

Улаангом сумын албан цахим хуудсан дээр иргэдийн дунд Хог хаягдлын менежментийг сайжруулахад тулгарч буй саад бэрхшээл юу вэ? Гэсэн асуултад нийт санал асуулгад оролцсон иргэдийн 36% нь хогны менежментийг сайжруулах чиглэлээр орон нутгийн нэгдсэн бодлого, зохицуулалт байхгүй гэж хариулсан ба энэ нь Увс аймаг тэр дундаа Улаангом суманд хог хаягдлын менежмент боловсруулан дагаж мөрдөх шаардлагатайг харуулж байна.

2.3 ХОГ ЦУГЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


Хог цуглуулах, тээвэрлэх үйлчилгээг орон нутгийн төсөвт үйлдвэр газар болох “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ гүйцэтгэдэг. “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ 2020 оны байдлаар ашиглагдаж буй хог тээврийн хөдлөх бүрэлдэхүүн дараах байдалтай болно /зураг 8/.

“Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ нь 2020 оны байдлаар 34 хүний бүтэц орон, тоотойгоор 14 төрлийн машин техникийн хүчээр доорх 5 төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Хог хаягдал
2. Ногоон байгууламж
3. Гудамж, талбайн гэрэлтүүлэг
4. Золбин нохой, муур устгал
5. Тохижилт үйлчилгээ гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 5 нэр төрлийн 30 ажил үйлчилгээг 93%-ийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэсэн гэж тайлагнасан байна.






Үүнээс хог хаягдлын ачилт тээвэрлэлтэд “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ-ын мэдээлэлснээр нийт хог тээврийн 4 машин, 1 ковш, 14 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагааг жилийн 4 улирал явуулж байна. Улаангом сумын хог хаягдал тээврийн 2020 оны тайланг үндэслэн харвал жилд гэр хорооллын хэмжээнд нийт 1671 машин хог хаягдал тээвэрлэсэн ба үүнийг жилийн 365 хонго амралтгүй ажилладаг гэж тооцвол өдөрт 4.6 шин хог хаягдал тээвэрлэдэг байх нь. Харин орон сууц хорооллын хувьд жилд нийт 1429 машин хог хаягдал гарсан ба энэ нь өдөрт 3.9 машин хог хаягдал тээвэрлэдэг.

д/д	Машин,техник	Марк	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн улс	Ашиглалтанд орсон он	Үнэлгээ	Төлөв
1		HD120	52-85УВА	Хятад	2000/11/01	33.798.659	Хуучин Запас сэлбэг байхгүй, засаж сайжруулаад явж байна
2		HINO DUTRO	79-67УВХ	ЯПОН	2020/06/09	40.000.000	Шинэ хэвийн ажиллаж байна

3		HINO RANGER	69-67УВХ	ЯПОН	2020/06/09	26.800.000	Шинэ хэвийн ажиллаж байна.
4		DFAC	24-55УВХ	ХЯТАД	2013/9/17	78.900.000	Эвдэрсэн. Актлах
5		ЗИЛ433360	86-37УВА	ОРОС	2015/12/31	23.000.000	Хуучин засаж сайжруулаад явж байна

6		LGB ЭКСКОВАТОР	93-00УВА	ХЯТАД	2008/12/31	60.000.000	Хуучин Эвдрэл гарсан.
7		HINO DUTRO	10-70УВА	СОЛОНГОС	2018/12/31	25.000.000	Хуучин засаж сайжруулаад явж байна
8		КОВШ ZL50H	67-98УН	ХЯТАД	2014/12/20	117.200.000	Хуучин засаж сайжруулаад явж байна. Кроп асуудалтай байгаа.

9		FOTON B.13253	97-06УВХ	ХЯТАД	2020/08/03	146.800.000	Шинэ хэвийн
10		LUOYANG T120N-3	99-84 УР	ХЯТАД	2019/12/31	148.000.000	Эвдрэл гарсан. Ажиллахгүй байгаа. Кропонд эвдрэл гарсан.
11		КОМАЗ КО-829А1	11-70УВХ	ОРОС	2014/10/03	149.800.000	Хэвийн

<p>12</p>		<p>MISTUBISHI FUSO</p>	<p>11-74УВА</p>	<p>ЯПОН</p>	<p>2018/12/31</p>	<p>35.000.000</p>	<p>Хуучин хэвийн</p>
<p>13</p>		<p>ТЭВШТЭЙ 3 ДУГУЙТ</p>	<p>6Ш</p>	<p>ХЯТАД</p>	<p>2020/01/01</p>	<p>НЭГ БҮР 3.000.000</p>	<p>Шинэ хэвийн</p>
<p>14</p>		<p>DAEWOO</p>		<p>СОЛОНГОС</p>	<p>2020/08/01</p>	<p>50.000.000</p>	<p>Шинэ хэвийн</p>

15		TOYOTO ESTIMA 0	30-25УВХ	ЯПОН	2015/4/01	10.000.000	Хуучин актлах
16		TOYOTA PROBOX	02-86 УВА	ЯПОН	2019/10/16	9.900.000	Шинэ хэвийн
17		ЗИЛ 130					Хуучин актлах

Зураг 7. Улаангом сумын хог тээврийн хөдлөх бүрэлдэхүүн

2.4 ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН ҮҮСЭХ ХЭМЖЭЭ


Улаангом суманд хог хаягдлын хэмжээ, бүтэц тодорхойлох судалгааг өмнө хийгдэж байгаагүй ба хог хаягдлын төвлөрсөн цэг дээр буулгаж буй хог хаягдлыг жинлэж буулгадаггүй зөвхөн тээвэрлэсэн рейсийн тоог тээвэрлэсэн машины метр кубийн хэмжээнд харьцуулан тойм тооцоо гаргаж байна. Иймд зайлшгүй хог хаягдлын цэг дээр өдөрт буулгаж буй хог хаягдлын хэмжээг нарын тооцож байх хэрэгтэй. Бидний зүгээс Улаангом суманд үүсэж болзошгүй хог хаягдлыг хог хаягдлын бүтцийн судалгаанд тулгуурлан тооцож үзлээ.

Улаангом сумын хог хаягдлын бүтцийн судалгаанд нийт айл өрхүүдээс 427 дээж цуглуулсан. Улаангом сумын гэр хорооллын өрхүүдээс нийт 10 айл өрхөөс 313 дээж, нийт 137,490 гр хог хаягдал цуглуулан ангилан ялгаж, хэмжилт хийсэн. Харин орон сууц хорооллын 4 айл өрхүүдээс нийт 114 дээж, нийт 29,280 гр хог хаягдал цуглуулан хэмжилт хийсэн.

Нэг хүний үүсгэж буй хог хаягдлын хэмжээг авч үзвэл гэр хорооллын нэг оршин суугч зуны улиралд 515.9 гр байна. Харин орон сууцны нэг оршин суугч зуны улиралд 355.4 гр хог хаягдлыг өдөрт гаргаж байна

Хэрвээ сууцны төрлийг харгалзалгүйгээр судалгаанд хамрагдсан бүх айл өрхийг авч үзвэл дунджаар 1 иргэн 1 хоногт зуны улиралд 451 гр хог хаягдал үүсгэж байна.


Хэрэв үүнийг Улаангом сумын нийт хүн ам буюу 32407 хүнд харьцуулж үзвэл өдөрт 14.2 тонн, сард 426 тонн, жилд 5,183 тонн хог хаягдлыг зөвхөн өрхийн хэмжээнд үүсэж байна.



Зураг 8. Сууцны төрлөөс хамаарсан нэг хүнээс үүсгэх хог хаягдлын хэмжээ /гр/

Бидний тооцоолсон хог хаягдлын хэмжээ /өрхөөс үүсэх/ жилд 5,183 тонн байсан бол “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ өнгөрсөн 2020 оны тайланд нийт 26135 м³ хог хаягдал цэвэрлэн тээвэрлэсэн гэсэн тооцоо гарсан байна. Харин байгаль орчны албан ёсны цахим хуудас буюу eic.mn-д тус аймгийн БОАЖГ бэлтгэн оруулсан БОХ тайлан мэдээнд Увс аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 66880.5 тонн хог хаягдал үүссэн ба үүний 89.4% буюу 59814.00 тонн нь Улаангом сумаас үүссэн, 2020 оны байдлаар Увс аймгийн хэмжээнд 72706.31 тонн хог хаягдал үүссэний 88.5% буюу 64320.00 тонн нь Улаангом сумаас үүссэн гэсэн тоо мэдээг тайланд оруулсан байна.

Үүнийг төв суурин болон хөдөө орон нутгаас үүсэх хог хаягдлын хэмжээтэй харьцуулан үзэхийн тулд Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаас үүсэж буй хог хаягдлын хэмжээтэй харьцуулан харуулж байна.



Зураг 9. Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаас үүсэж буй хог хаягдлын хэмжээ

Улсын хэмжээнд 2018 онд зөвшөөрөгдсөн 390 хог хаягдлын төвлөрсөн цэгт нийт 3,353,548.73 тонн хог хаягдал тээвэрлэн зайлуулжээ.

2018 оны байдлаар төвлөрсөн хогийн цэгт хүргэж, дарж булж буй нийт хог хаягдлын 41.6% буюу 1,393,753 тн нь Улаанбаатар хотод үүссэн бол үлдсэн 58.4% буюу 1,959,795 тн хог хаягдал нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн байна.


Төв суурин газар болон хөдөө орон нутгаас үүсэх хог хаягдлын хэмжээг дээрх байдлаар харьцуулж үзэж байгаа ба үүнийг хүн амын эзлэх хувьтай харьцуулж үзэхэд 2020 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 3,357,542 хүн амтай байсан ба үүний 1,760,252 нь хөдөө орон нутагт, 1,597,290 нь Улаанбаатар хотод төвлөрч суурьшиж байна. Үүнийг хувиар авч үзвэл Монгол улсын нийт хүн амын 52.4% нь хөдөө орон нутагт, 47.6% нь Улаанбаатар хотод амьдарч байна. Харин Увс аймгийн хувьд 2020 оны байдлаар 84,294 хүн тоологдсон ба үүний 32,407 нь Улаангом суманд амьдарч байна. Үүнийг хувиар авч үзвэл Увс аймгийн нийт хүн амын 38.4% нь Улаангом суманд харьяалагдаж байна.

Тээвэрлэлтэд явж байгаа машинууд нь гэр хороололд 20м^3 багтаамжтай машин явдаг бол орон сууц хорооллын хог хаягдлын тээвэрт 3.5м^3 багтаамжтай машин явж байна. Үүнээс үндэслэн тооцвол Улаангом сумын хэмжээнд гэр хорооллын 6700 орчим өрх амьдардаг бол орон сууц хороололд 1450 өрх амьдарч байна.

Үүнээс нийт жилийн хог хаягдлын дүнг өрхийн тоотой харьцуулж үзвэл гэр хорооллын нэг өрхөөс жилд 3.2м^3 хог хаягдал үүсдэг байна. Харин орон сууц хорооллын нэг өрхөөс жилд 3.4м^3 хог хаягдал гардаг байна.


Үүнийг бидний гүйцэтгэсэн хог хаягдлын бүтцийн судалгаатай харьцуулбал гэр хорооллын нэг иргэнээс зуны улиралд өдөрт 516гр хог хаягдал гардаг, харин өвлийн улиралд үүсэх хог хаягдлын хэмжээг өмнөх хийгдсэн хог хаягдлын бүтцийн судалгаануудтай харьцуулахад зуны

улирлаас 2.5 дахин их хаягдал үүсдэг байна. Ингэж үзвэл Улаангом сумын гэр хорооллын нэг иргэнээс өвлийн улиралд 1290гр хог хаягдал үүсэж байна.



Зураг 10. Улаангом сумын нэг иргэнээс үүсэх хог хаягдлын хэмжээ /гр/

Монгол орны хүйтний буюу галлагааны улирал дунджаар 10-р сараас 4-р сар гэж тооцдог гэж үзвэл Улаангом сумын гэр хорооллын нэг өрхөөс өвлийн улиралд 1,154 кг хог хаягдал, зуны улиралд 329кг хог хаягдал үүсдэг байна. Жилд нийт гэр хорооллын нэг өрхөөс 1,483кг хог хаягдал үүсдэг. Харин орон сууц хорооллын нэг иргэнээс өдөрт 356гр хог хаягдал үүсдэг гэж үзвэл Улаангом сумын орон сууц хорооллын нэг өрхөөс жилд 546кг хог хаягдал үүсдэг байна /ойролцоогоор/.




Зураг 11. Улаангом сумын нэг өрхөөс жилд үүсэх хог хаягдлын хэмжээ /кг/

Үүнээс тооцож үзвэл гэр хорооллын нэг өрхөөс 1м³-д 463кг хог хаягдал ноогдож, орон сууц хорооллын нэг өрхөд 1м³-д 161кг хог хаягдал ноогдож байна.


“Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ хог хаягдал тээвэрлэсэн 2020 оны тайланг

харьцуулж тооцвол Улаангом сумын хэмжээнд гэр хорооллоос жилд 21135м^3 хаягдлыг тээвэрлэсэн ба энэ нь $9,785$ тонн хог хаягдал үүсдэг бол орон сууц хорооллоос 5000м^3 хаягдлыг тээвэрлэсэн ба энэ нь 805 тонн хог хаягдал үүсдэг байна. Нийт Улаангом сумын өрхийн хэмжээнд жилд нийт 26135м^3 хог хаягдал үүссэн ба энэ нь 10.590 тонн хог хаягдал үүсдэг гэж тооцож байна /ойролцоогоор/.



Зураг 12. “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ хог хаягдал тээвэрлэсэн 2020 оны тайланг харьцуулж тооцвол жилд үүсэх хог хаягдлын хэмжээ /тонн/

Бидний гүйцэтгэсэн хог хаягдлын бүтцийн судалгааг Улаангом сумын нийт өрхийн тоо мэдээтэй харьцуулж тооцвол Улаангом сумын хэмжээнд гэр хорооллын 6700 өрхөөс жилд $9,936$ тонн хог хаягдал үүсдэг бол орон сууц хорооллын 1450 өрхөөс жилд 792 тонн хог хаягдал үүсдэг байна. Нийт Улаангом сумын өрхийн хэмжээнд жилд нийт 10.728 тонн хог хаягдал үүсдэг /ойролцоогоор/.



Зураг 13. Хог хаягдлын бүтцийн судалгааг Улаангом сумын нийт өрхийн тоо мэдээтэй харьцуулж тооцвол жилд үүсэх хог хаягдлын хэмжээ /тонн/

2.5 ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАН ЯЛГАЖ БУЙ НӨХЦӨЛ

2019 онд Байгаль очин аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санаачлагчаар нийт 8 аймагт дахивар хог хаягдлын ангилан ялгах ажлын дэмжих зорилгоор хог хаягдлын овор хэмжээг бууруулах бутлагч төхөөрөмжийг нийлүүлсэн ба 2020 онд мөн Байгаль очин аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санаачлагчаар нийт 21 аймагт хог хаягдлын ангилан ялгах ажлын дэмжих зорилгоор дахивар хаягдлын овор хэмжээг бутлагч пресслэгч төхөөрөмжүүдийг нийлүүлсэн. Тус төхөөрөмжүүд гэрээ ёсоор Увс аймгийн БОАЖГ-ын өмч ба гэрээгээр дахивар хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, эрхлэх хувь хүн болон ААН-д хариуцуулан ажиллах юм.



Зураг 14. Увс аймагт хүлээлгэн өгсөн дахивар хаягдал бутлах төхөөрөмж





Зураг 15. Увс аймагт хүлээлгэн өгсөн дахивар хаягдлын овор хэмжээг бууруулах нягтруулагч төхөөрөмж

Тус төхөөрөмжүүд нь өдөрт 2 тонн дахивар хаягдлыг бутлах, пресслэх хүчин чадалтай төхөөрөмжүүд юм. Одоогийн байдлаар Увс аймагт дахивар хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн, ААН тус төхөөрөмжүүдийг БОАЖГ-тай гэрээлэн үйл ажиллагааг хэрэгжүүлж ашиглаж эхлээгүй байна.

2.6 ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаангом сумын төвлөрсөн хогийн цэг нь хотын төвөөс баруун өмнө зүгт ойролцоогоор 4 км зайд орших ба 20 орчим жил ашиглагдаж байна. Уулын хөндийд тэгш талархуу газарт байршсан, хэдийгээр алслагдсан боловч хогийн цэгийг стандартын дагуу байгуулаагүй, зөвхөн намхан хашаа хийсэн тул хүчтэй салхины нөлөөгөөр очны бохирдол их хэмжээгээр үүсгэж байна.

Төвлөрсөн хогийн цэгт хүнд механизм ажилладаггүй, хогийн цэгийн хил тодорхойгүй тул тус цэг рүү тээвэрлэгдэж буй хогийг цэгийн орчмын нэвтрэх боломжит талбайд шүүд асгаж байгаа ба үүнээс үүдэн хогоор дүүрсэн талбай өдрөөс өдөрт өргөжиж байна.

Төвлөрсөн цэг рүү нэвтрэх хэсэгт бүртгэлийн алба ажилладаггүй болон хаягдаж байгаа хог хаягдлыг жинлэж хаядгүйн улмаас жилд, сард, хоногт хэдий хэмжээний хог хаягдал хогийн цэгт хаягддаг нь тодорхойгүй байна.

Мөн Улаангом сумын хэмжээнд бүртгэлтэй нийт 1200 ААН байдаг ба 2020 оны байдлаар “Улаангом тохижилт үйлчилгээ” ОНТҮГ ердөө 67 ААН-тэй гэрээ байгуулан хог хаягдлын тээвэрлэсэн ба бусад ААН ямар замаар хаана яаж хог хаягдлаа хаядаг нь тодорхойгүй байна.



Зураг 16 Хог хаягдлын төвлөрсөн цэг

Дээрх тоон мэдээнүүд нь Увс аймгийн Улаангом сумын хэмжээнд бүртгэгдсэн тоон мэдээллүүд ба аймгийн хэмжээний хог хаягдлын тоон мэдээ болон томоохон уул уурхайнуудаас үүсэж буй хог хаягдлын тоон мэдээ хангалттай хэмжээний бүргэл хийгдэдгүй учир нарийн тооцоолол хийх тоон мэдээ дутмаг байна. Иймээс хог хаягдлын зохистой менежментийн урт хугацаанд хэрэгжүүлэхийн тулд бид үүсэж буй хог хаягдлын нэр төрөл болон тоон мэдээг нарийвчлан бүртгэлжүүлэх шаардлагатай.



2.7 УЛААНГОМ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Улаангом сумын хэмжээнд сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт, хотжилт хурдацтай явагдаж байна. Үүнээс үүдэн хог хаягдал ил задгай хаях иргэдийн хог хаягдлын мэдлэг ойлголт дутмаг, хог хаягдалтай зүй зохистой харьцахгүй байгаа зэргээс үүдэн орчны бохирдол их хэмжээгээр үүсэх хандлагатай байна.

Увс аймгийн хог хаягдлын менежментэд тулгамдаж буй асуудлууд. Үүнд:

1. **Төр засаг, хувийн хэвшил, олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлж хариуцлагын тогтолцоог сайжруулах**
 - Айл өрхийн хог хаягдлын ангилан ялгалтад хяналт тавих, ТББ, хөршийн холбоо, СӨХ, сайн дурын иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хамтарч ажиллах, урамшуулах. Сар бүрийн сүүлийн долоо хоногийн баасан, бямба гаригт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж хэвшүүлэх
2. **Хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх, ялгах, дахин боловсруулах ажлыг сайжруулж байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай хог хаягдлыг дарж булшлах**
 - Хогийн цэг рүү хүртэлх авто замыг хатуу хучилттай болгох
 - Шинээр ландфилын хогийн цэг байгуулах зураг төсөв боловсруулах
 - Зураг төслийн дагуу стандартын Ландфилын хогийн цэгийг барьж ашиглалтад оруулах
 - Хог хаягдлын тээврийн авто машин, тоног төхөөрөмж, ажиллах хүчийг нэмэгдүүлэх
3. **Хог хаягдлын талаарх иргэд, олон нийтийн мэдлэг ухамсрыг дээшлүүлэх**
 - Аж ахуй нэгж байгууллага, иргэдийг хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах
 - Сургууль цэцэрлэгийн сурагчдад хог хаягдлын болон ангилан ялгах, хотын соёлын талаар шат дараатай сургалт зохион байгуулах
 - Иргэдийн дунд хог хаягдал ангилж ялгах, зүй зохистой хаях талаарх мэдлэг ойлголтыг төлөвлөлт гарган тогтмол мэдээлэл хүргэх
 - Иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх урамшуулалт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах
4. **Хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр ангилан ялгаж, гарах хог хаягдлын хэмжээг багасгах ажиллагааг дэмжих**
 - Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эх үүсвэр дээр нь ангилан ялгах савыг нэмэгдүүлэх
 - Батлагдаж буй журмын хэрэгжилтэд хяналт тавих, ААН байгууллагуудыг хог хаягдлаа ангилж хаях зориулалтын хогийн савтай байхыг шаардах
 - Гэр хороолол, орон сууц хороолол, нийтийн зам талбайн дагуу зориулалтын ангилалтын савууд бий болгох
5. **Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах**
 - Зам талбайн цэвэрлэх бага оврын тоног төхөөрөмжтэй болох
6. **Дахивар хаягдлыг бэлтгэн нийлүүлэх, боловсруулах үйл ажиллагааг дэмжих**
 - Дахивар хаягдал бэлтгэн нийлүүлэх дэд бүтцийг нэмэгдүүлэх

- Дахивар хаягдлыг тодорхой хэмжээгээр үнэлж худалдаж авдаг цэгүүд, сүлжээ бий болох
- Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн ААН-ыг бодлогоор дэмжих

2.8 ХОГ ХАЯГДЛААС ҮҮСЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛ, НӨЛӨӨЛӨЛ

Монгол улс нь 2000-аад оны эхнээс нэлээд эрчимтэй хөгжиж, өргөжин тэлж байна. Үүнийг дагаад хог хаягдлын хэмжээ ч өсөн нэмэгдэж, 2009 оныхтой харьцуулахад хогийн цэгүүдэд тээвэрлэгдэн очиж байгаа нийт хог хаягдлын хэмжээ 7 дахин өссөн байна. Үүний зэрэгцээ Монгол орны хүн ам хурдацтай нэмэгдэхийн хэрээр хөдөө нүүдэлчин аж ахуй эрхлэх иргэд цөөрч суурин амьдралын хэв маягт хурдацтайгаар шилжих болжээ. Үүний хэрээр хот суурин газрын хүн ам мөн хурдацтай өсөж байна.

Улаангом сумын хувьд 2010 оны байдлаар нийт иргэдийн тоо 24,530 байсан бол 2020 он гэхэд 32,470-д хүрчээ. Мөн хүн ам нэмэгдэхийн зэрэгцээ суурин амьдралд суралцаж буй Монгол хүмүүсийн хувьд байгаль орчинтой зүй зохистой харьцах хандлага дутмаг байгаа учраас байгаль орчинд үзүүлэх, тэр дундаа хог хаягдлаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө их хэмжээгээр үүсч байна.

Иймээс бид тус ажлын хүрээнд Улаангом сумын хэмжээнд дараах 4 цэгээс хөрсний дээж авч хөрсөнд хуримтлагдсан хүнд металлын бохирдлыг тодорхойлсон. Үүнд:

1. Гэр хорооллын гудамж талбайгаас-SS#01
2. Барилгажсан хорооллын хэсгээс-SS#02
3. Хог хаягдлын төвлөрсөн цэгээс-SS#03
4. Хүний нөлөөлөлд өртөөгүй эрүүл газраас-SS#04



Зураг 17. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил

2.8.1 ХӨРСНИЙ ДЭЭЖ АВАЛТ

Хөрсний бохирдлын дээжийг дугтуйн аргаар 25 м² газрыг төлөөлүүлж, хааш хаашаа 5 м газарт 4 булан болон төв цэгээс нийт 5 дээж авч холив нэг цэгийн дээж бүрдэнэ. Дээжийн хэмжээ дунджаар 500 гр, дээж авах гүн 0-10 см. Хөрсний бохирдлын дээж авахдаа MNS 3298-90 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд стандартад заасны дагуу гүйцэтгэв. Нийт Улаангом сумын хэмжээнд хөрсний бохирдол үүсэж болзошгүй 4 бүсээс төлөөлүүлэн дээж авсан болно.



Зураг 18. Хөрсний дээж авалт

2.8.2 УЛААНГОМ СУМЫН ХӨРСНИЙ ЕРӨНХИЙ

Улаангом сум нь Алтайн уулархаг мужийн салбар уулс болох далайн түвшнээс дээш 2781-3280 м өргөгдсөн Хархираа, Түргэний уулсын Зүүн хойд хөндийд буюу уулс хоорондын хотсын захын хэсэгт хамааран байрлана. Хот байрлах газрын гадаргуу 920-1050 метрийн үнэмлэхүй өндөртэй, баруунаас зүүн тийш 5-7 градусын налуутай, гадаргуугийн хэрчигдэл харьцангуй багатай.

Тус хотын нутаг дэвсгэр нь Хархираа, Түргэний уулсаас эх авсан олон гол, горхи, сайр хөндийн хэсгийн цутгал газар болох учраас хур тундас ихтэй, хасах температур өндөртэй.

Улаангом хотын нутаг дэвсгэрт дээд ба орчин үеийн дөрөвдөгчийн настай Алюви-пролювийн хурдасны уст давхрага, Неоген дээд дөрөвдөгчийн настай Нуур, Аллюви-пролювийн хурдасны уст давхарга, Гүний болон бялхмал чулуулгийн уст давхарга гэсэн 3 үеийн уст давхрагууд ялгагддаг. Энэ уст давхаргын ус агуулагч гол хөрс нь сайр, сайрга агуулсан элсэнцэр, шавранцар болон янз бүрийн төрлийн том, хэмхдэст хөрс байна. Уст давхаргын зузаан 10-30 м бөгөөд чөлөөт гадаргатай, хур тунадасны болон гадаргын усаар тэжээгдэнэ.

Улаангом сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд Силур, Девоны настай гүний чулуулаг, Дээд дөрөвдөгч-Неогений настай Нуур-аллюви-аллювийн элсэнцэр, шавранцараар чигжигдсэн том хэмхдэст хөрс, шавранцар, шавар хөрснүүд голлон тархана. Геофизикийн судалгаагаар уг хөрсний зузаан 14-200 м хүрдэг. Дээд дөрөвдөгчийн настай аллюви-пролювийн гаралтай элс, элсэнцэр, шавранцраар чигжигдсэн хайргат том хэмхдэст хөрс төвийн хэсгээр зонхилон 10-30 м-ийн зузаантай тархана.

Улаангом хотын үл хөрсний геотехникийн нөхцөлийн онцлог:

- Аллюви-пролювийн гаралтай элс, элсэнцэр, шавранцраар чигжигдсэн том хэмхдэст хөрс төвийн хэсгээр зонхилон 10-30 м-ийн зузаантай тархана.
- Ул хөрсний зонхилох төрлүүд нь хүйтний овойлт үүсгэдэг тул барилга байгууламжийн суурийн төлөвлөлтөд хөрсний овойлтын эсрэг арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.



Зураг 19. Улаангом орчмын хөрсний хэв шинж

2.8.3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2016 онд Увс аймгийн ЦУОШГ Улаангом сумын хэмжээнд нийт 16 цэгээс хөрсний дээжинд кадмий, хартугалга, мөнгөн ус, бром, хром, цайр, зэс, кобальт, стронций, рубиди, циркон, хлор зэрэг 12 хүнд металлын шинжилгээ хийгдсэн.


Шинжилгээний дүнгээс үзэхэд: Хөрсний чанарын шинжилгээгээр кадмийн дундаж агууламж 0.4 мг/кг, хартугалганы дундаж агууламж 35.8 мг/кг, мөнгөн усны дундаж агууламж 0.1 мг/кг, вромын дундаж агууламж 1.5 мг/кг, хромын дундаж агууламж 16.8 мг/кг, цайрын дундаж агууламж 38.3 мг/кг, зэсийн дундаж агууламж 27.6 мг/кг, кобальтын дундаж агууламж 31.6 мг/кг, стронцийн дундаж агууламж 410.9 мг/кг, рубидийн дундаж агууламж 141.8 мг/кг, цирконий дундаж агууламж 304.4 мг/кг буюу MNS 5850:2008 стандарттай харьцуулахад арьс шир дулааны станцын ойролцоох цэгт хромын агууламж ХА-аас 1.5 дахин, цайрын агууламж 11 цэгт ХА-аас 1-2.9 дахин давсан ба бусад үзүүлэлтээр ХА-аас давсан агууламжгүй хэвийн гэсэн дүн гарсан байна.

Доорх графикуудаас 2016 оны хүнд металлын агууламжууд болон 2021 оны цэгүүдээс авсан хөрсний дээжинд илэрсэн хүнд металлуудын агууламжыг харьцуулан харуулав.




Зураг 20. Хөрсөн дэхь Кадмийн агууламж мг/кг

2016 оны байдлаар Улаангом сумын хөрсөнд агуулагдах кадмийн агууламж дунджаар 0.4мг/кг байсан бол 2021 оны дээжинд 1-1.26 мг/кг болж өссөн байна. Хамгийн өндөр агууламжтай нь хог хаягдлын төвлөрсөн цэгээс авсан дээжинд 1.26мг/кг байна.




Зураг 21. Хөрсөнд агуулагдах хар тугалганы хэмжээ мг/кг




Зураг 22. Хөрсөнд агуулагдах хүнцэлийн агууламж мг/кг

Бусад дээжүүдтэй харьцуулахад хүнцэл болон хар тугалганы агууламж хог хаягдлын нэгдсэн цэг дээрээс авсан дээжинд хүлцэх агууламжинд дөхсөн үзүүлэлтүүд ажиглагдаж байна. Энэ нь Улаангом сумын хэмжээнд хог хаягдлаас үүсэх орчны бохирдол, доройтолд хог хаягдлийн менежментээр дамжуулан зүй зохистой үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.




Зураг 23. Хөрсөнд агуулагдах хромын хэмжээ мг/кг

Хөрсөнд агуулагдах хромын хэмжээ хүлцэх агууламжаас давсан утга байхгүй хэвийн хэмжээнд байгаа боловч 2016 оны дундаж агууламжийн дүнтэй харьцуулахад бүх цэгүүд 2-3 дахин өссөн хэмжээ ажиглагдаж байна.



Зураг 24. Хөрсөнд агуулагдах цайрын агууламж мг/кг



Зураг 25. Хөрсөнд агуулагдах зэсийн агууламж мг/кг

Судалгааны нийт дүнгээс үзэхэд нийт авсан дээжинд хүлцэх агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй хэвийн байдалтай байна. Гэхдээ Увс амгийн ЦУОШГ 2016 онд гүйцэтгэсэн хөрсний хүнд металлын бохирдлын дүнтэй харьцуулхад дариу 2-3 дахин бохирдлын хэмжээ нэмэгдсэн байдал ажиглагдаж байна. Нийд тоон мэдээн дунаас мөн хог хаягдлын цэгээс авсан дээжинд агуулагдах хүнд металлын агууламж бусад цэгүүдтэй харьцуулхад өндөр байсан. Жишээ нь As буюу хүнцэлийн агууламж хог хаягдлын төвлөрсөн цэг орчын хөрсөнд 19.85 мг/кг байна. Энэ нь хүлцэх агууламж 20 мг/кг-д дөхсөн үзүүлэлт юм. Мөн Pb буюу хар тугалгын агууламж мөн адил бусад цэгүүдэд 5 мг/кг орчим байхад хог хаягдлын цэг орчмын хөрсөнд 89.29 мг/кг байна. Энэ нь хүлцэх агууламж 100 мг/кг дүнд хараахан хүрээгүй дүн ч гэсэн 2016 оны дүнтэй харьцуулахад бохирдлын хэмжээ 4 жилийн дотор огцом өссөн байгааг илэрийлж байна гэж үзэж байна.

ЗАХИАЛГА №: 2021/1804		ХАНЛАБ ХХК								Улаанбаатар хог, Хан-Уул дүүрэг, 17-р хороо, Богд Жавзандамба гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр					Утас: 70109968, 99995316		http://www.khanlab.mn	
ЗАХИАЛАГЧИЙН НЭР:		МОГ ПЛАСТИК ХХК								ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО:					Хөрс, 4			
№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, %					ЭЛЕМЕНТ, мг/кг									
				Al*	Ca	Mg	K	Fe _{снiт}	As	Ba*	Be	Bi	Cd					
1	Л-26750	SS#01	Хөрс	7.71	3.44	1.71	1.78	3.83	15.35	456.8	<5.0	<10.0	<1.0					
2	Л-26751	SS#02	Хөрс	6.52	2.32	1.55	1.91	3.48	13.33	456.8	<5.0	<10.0	<1.0					
3	Л-26752	SS#03	Хөрс	5.48	1.59	1.35	1.21	2.78	19.85	445.0	<5.0	<10.0	1.26					
4	Л-26753	SS#04	Хөрс	6.47	1.59	1.63	1.96	3.56	10.84	493.2	<5.0	<10.0	<1.0					
MNS5850:2019				-	-	-	-	-	20.00	-	-	-	3.00					
№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, мг/кг														
				Co	Cr	Cu	La	Li	Mn	Mo	Ni	P	Pb					
1	Л-26750	SS#01	Хөрс	21.87	70.3	42.06	26.41	32.83	899.6	<5.0	33.30	612.0	5.87					
	Л-26751	SS#02	Хөрс	18.40	63.1	31.11	24.73	30.31	876.3	<5.0	31.94	674.8	<5.0					
	Л-26752	SS#03	Хөрс	14.31	68.5	39.79	27.39	28.81	735.3	<5.0	28.06	984.4	89.29					
2	Л-26753	SS#04	Хөрс	19.23	63.9	26.84	23.64	31.11	1108.4	<5.0	33.89	737.8	<5.0					
MNS5850:2019				50.00	150.0	100.0	-	-	-	5.0	150.0	-	100.0					
№	ЛАБОРАТОРИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ДУГААР	ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ	ЭЛЕМЕНТ, мг/кг														
				Sb	Se	Sr*	Ti	V	Y	Zn	Zr*							
1	Л-26750	SS#01	Хөрс	<10.0	<5.0	239.7	5769	117.4	21.08	54.88	82.81							
	Л-26751	SS#02	Хөрс	<10.0	<5.0	200.7	4584	98.0	18.78	51.29	72.07							
	Л-26752	SS#03	Хөрс	<10.0	5.89	178.7	3275	65.2	18.65	126.43	87.57							
2	Л-26753	SS#04	Хөрс	<10.0	<5.0	202.7	4841	103.0	17.50	38.98	67.36							
MNS5850:2019				-	10.00	800.0	-	150.0	-	300.0	-							
Дэд захирал				С.Туул, PhD														


Зураг 26. Хөрсний шинжилгээгээр хийгдсэн нийт үзүүлэлтэд

2016 онд хийгдсэн Улаангом сумын Ус цаг уурын газраас хийгдсэн хөрсний бохирдлын судалгааг энэ онд хийсэн судалгаатай харьцуулбал Улаангом сумын хог хаягдал төвлөрсөн газруудад хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс давахаар харагдаж байна.

№	Хүнд металл	2021	2016	1 жилд нэмэгдэх	Хүлцэх агууламж	Хүлцэх агууламжид хүрэх хугацаа /жил
1	Ave	Cd	1.065	0.4	0.133	3
2		Pb	26.29	35.8	-1.902	100
3		As	14.8425			20
4		Cr	66.475	16.8	9.935	150
5		Zn	67.8475	38.3	5.9095	300
6		Cu	34.95	27.6	1.47	100
7	Max	Cd	1.26	0.4	0.172	3
8		Pb	89.29	35.8	10.698	100
9		As	19.85			20
10		Cr	70.3	16.8	10.7	150
11		Zn	126.4	38.3	17.62	300
12		Cu	42.06	27.6	2.892	100

2.9 ОДООГИЙН МӨНГӨНИЙ УРСГАЛ, САНХҮҮЖИЛТ

Улаангом сумын хог хаягдлын менежментэд зарцуулагдаж байгаа санхүүгийн бүрдэл нь оновчгүй байна. Мөн боломжит бүрдүүлэлтийг бүрэн дүүрэн ашиглахгүй байна.



Энэ нь хог хаягдал хандах хандлага, хариуцлагыг сулруулж байна. Үүний улмаас орчны бохирдол ихсэж зөвшөөрөгдөх хэмжээнээс давахад тун ойрхон ирээд байна.

3 ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилго нь Увс аймгийн Улаангом сумын хог хаягдлын менежментийн нөхцөл байдлыг тодорхойлох, хүндрэлтэй асуудлуудыг тогтоох, улмаар сайжруулах арга замыг төлөвлөх явдал юм. Ялангуяа Улаангом сумын айл өрх, албан байгууллагаас үүсэх хог хаягдлын бүтцийг судлах бөгөөнд үүнд үндэслэн суманд хог хаягдал дахин боловсруулах боломжтой үйлдвэрийг судлах, төвлөрсөн хогийн цэг дээр ил задгай хаягдлаас үүдэх орчны бохирдлыг багасгах, түүнчлэн төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг сайжруулах, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэхэд оршино.

Төлөвлөгөөг Улаангом сумын цар хүрээ, төвлөрсөн хогийн цэгт хаягдах хогны хэмжээ, тус аймгийн газар нутаг дээр үүсэх боломжтой хог хаягдлыг тооцоолон хэрэгжих боломжийг харгалзан үзэж боловсруулахыг зорилоо.

ЗОРИЛТОТ 2030 ОН ХҮРТЭЛ УЛААНГОМ СУМЫН БАЙГАЛЬ ОРЧИНД ХАЛГҮЙ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ БИЙ БОЛГОХОД ОРШИНО.

Энэхүү системийг бий болгохын тулд:

- Айл өрх ба ААН, байгууллагуудыг хог хаягдлаа эх үүсвэр дээрээ ялган ангилахыг дэмжих
- Нэгэнт үүсэж байгаа хог хаягдлыг дахин ашиглаж хэрэглээнд дахин оруулахыг эрмэлзэх
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах хүчин чармайлт гаргасны дараагаар ачиж цуглуулах, ялгах, боловсруулах ажлуудыг хийж цэсийн шатанд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй дулааны аргаар устгах эсвэл хогийн цэг дээр булж устгана.
- Нээлттэй, шударга зарчим баримтлан Орон нутгийн удирдлага болон хувийн хэвшил, олон нийт тус тусын зохих хариуцлагаа хүлээж энэхүү хог хаягдлын менежментийг бий болгох болно.

3.1 ЗОРИЛТУУД

Дээр дурдсан зорилгод аажмаар хүрэх бөгөөд Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тусын зорилгод дараах байдлаар хуваана.

3.1.1 БОГИНО ХУГАЦААНД САЙЖРУУЛАХ – ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМЫГ САЙЖРУУЛАХ

- Хууль эрхзүйн сайжруулалт
- Хог хаягдлын ялган ангилалтыг хяналт тавих, хариуцлага тооцох
- Зохисгүй байдлаар хог хаях байдлыг арилгах
- Иргэд ААН-ийг дэмжих
- Олон нийтэд хэвшил суулгах

3.1.2 ДУНД ХУГАЦААНЫ САЙЖРУУЛАЛТ –ЭДИЙН ЗАСГИЙН ХӨШҮҮРГИЙГ БИЙ БОЛГОХ

- Байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг дэмжих
- Аюултай хог хаягдлыг хяналттай болгож, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах
- Хог хаягдлын цуглуулах ажиллах байгаа ЖДҮйлдвэрлэгч нарын аймгийн хог хаягдлын сангаас дэмжих

- Тодорхой хэмжээнд Хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах чиглэлд ажиллах байгаа иргэдийг эдийн засгийн хувьд дэмжих
- Ялган ангилах төслийн үйл ажиллагааг тогтмолжуулах
- Дахин боловсруулах боломжит үйлдвэрлэлүүдийг байгуулах, дэмжих

3.1.3 УРТ ХУГАЦААНД – БОЛОВСРОЛЫН САЛБАРААР НӨЛӨӨЛӨХ

- Цэцэрлэг болон ЕБС-ийн нийгмийн ажилтнуудыг хог хаягдлыг сургагч багшаар бэлтгэж
- Хүүхдийн насны онцлогт тохиорсон хог хаягдлыг ялган хаяхын ач тусыг ойлгуулсан сургалт, сурталчилгаа, ухуулах үйл ажиллагааг зохион байгуулж, ухамсарт суулгах
- Олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлж, зөв дадал, сэтгэлгээг төлөвшүүлэх, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх

4 СТРАТЕГИ

Мастер төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төлөвлөгөөний гурван үе шатны тус бүрийн стратеги боловсруулах бөгөөд тэдгээрийг дараах байдлаар тодорхойлов.

Зорилт	Хийгдэх ажлууд
БОГИНО ХУГАЦААНД САЙЖРУУЛАХ	
Зохисгүй байдлаар хог хаях байдлыг арилгах	Иргэдийн боловсрол, сурталчилгааны кампанит ажиг болон хуулийн хэрэгжилтийг хангах замаар 2025 он гэхэд хууль бус хог хаягдал, хог хаягдлыг зохимжгүй байдлаар өөрөө устгах зэрэг анхан шатны эх үүсвэр дээр зохисгүй хаях байдлыг арилгах
	Нэгдсэн хогийн цэгийг битүүмжлэлийн сайжруулан зөвхөн зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл орох
	Сумын төвийн хогийн цэгүүдийн орчмын камержуулалтыг сайжруулан, хяналт тавин зөрчил гаргасан ААН, байгууллагуудад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах
Эх үүсвэр дээр ангилан ялгах	Барилгын хог хаягдал үүсгэгч ААН, иргэдэд хяналт тавьж ажиллах
	Орон сууцны хогны бункерийн ашиглалтыг хориглож, эх үүсвэр дээрээ ялган ангилах боломж бүхий хогийн саваар хангаж, ялган ангилах боломжийг бий болгох.
	Сумын хэмжээнд хог хаягдал замбараагүй тархахаас сэргийлж хог хаягдлыг цуглуулах ажлыг сайжруулна.
	2022 оноос дахивар хаягдал, хүнсний хаягдал болон бусад гэсэн байдлаар хог хаягдлыг ангилж хаядаг болно. 2023 он гэхэд орон сууцны хорооллын нийт оршин суугчдад хог хаягдлыг ангилан цуглуулах тогтолцоо нэвтрүүлнэ.
	Ялган ангилах үйл ажиллагааг сурталчлах, ялган ангилж байгаа иргэд ААН-ийг дэмжих, урамшуулж ажиллах
	Айл өрх, ААН, байгууллага олон нийтийг хамарсан Хог хаягдлаа эх үүсвэр дээрээ ангилах хаяхыг ач тусыг харуулсан контент бэлтгэн хүргэх
	Шинээр баригдаж байгаа барилгад ялган ангилах савыг зайлшгүй оруулах
Хог хаягдал цуглуулах тогтолцоог сайжруулах	Өнгөрсөн хугацаанд БОАЖЯамнаас хэрэгжүүлж байгаа орон нутгийн дахиврын сүлжээ байгуулах ажиллагааг дэмжин, үргэлжлүүлэх
	Гэр хорооллын бүсэд хог хаях журам нэвтрүүлж тэрхүү бүсийн нийт оршин суугчдад хог хаягдал цуглуулах үйлчилгээ үзүүлнэ.
	Нийтийн эзэмшил газрыг гар аргаар цэвэрлэх одоогийн байдлыг хадгалж үргэлжлүүлнэ. Сумын хэмжээнд хог хаягдал замбараагүй тарах байдлаас сэргийлэх зорилгоор иргэд, оршин суугчдын дунд боловсрол, сурталчилгааны кампанит ажлыг зохион байгуулж хуулийн хэрэгжилтийг хангана.
	Дахивар хог хаягдлын тээвэрлэлт, цуглуулалтын үйл ажиллагаанд хувийн хэвшлийг татан оролцуулах. Дахивар хаягдлын үнэ төлбөргүй тээвэрлэх боломжийг бий болгох
Хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах тогтолцоог бий болгох	Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг дахин ашиглаж түүхий эд болгохын сацуу хог хаягдал гаргах анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлын хэмжээг багасгах зорилгоор төрийн секторын оролцоотой үйл ажиллагааг дэмжих ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.

Зорилт	Хийгдэх ажлууд
	Хувийн хэвшлийн дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлэх тогтолцоог бий болгоно.
	Тэрхүү төлөвлөгөөний нэг бүрэлдэхүүн хэсэг нь хувийн хэвшлийг татах зорилгоор дахивар хаягдлын төв (ДХТ)-ийг байгуулж хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжинэ.
Хогийн төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг сайжруулах	Улаангом сумын одоогийн хогийн төвлөрсөн цэг дээр эрүүл ахуйн шаардлага хангах ландшафлыг нэвтрүүлж хог түүгч нарыг зохион байгуулалтад оруулах ажлыг дэмжинэ.
	Төвлөрсөн хогийн цэгийг одоогийн орчин нөхцөлийг сайжруулах төлөвлөгөө боловсруулж аймгийн төсөвт оруулан батлуулж ажиллах
	Төвлөрсөн хогийн цэгт автопүү болон автомат бүртгэлийн системийг нэвтрүүлж, ТҮК-ны тээврийн үйл ажиллагаанд давхарт хяналт тавихаас гадна ААН, байгууллагууд өөрсдөө хаягдлаа буулгах ажиллагааг бүртгэлжүүлж нэмэлт төлбөрийн эх үүсвэрийг бий болгоно
Эмнэлгийн болон үйлдвэрийн аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах	Эмнэлгийн хог хаягдлыг (халдвартай/аюултай хог хаягдал) эх үүсвэр дээр нь ялгах, боловсруулах болон ангилан хаях/цуглуулах ажлыг хийлгэнэ.
	Эмнэлгийн болон аюултай хог хаягдлыг устгах зориулалт байгаль орчинд нөлөөгүй дулааны аргаар устгах зүүхыг авч дахивар хаягдлын төв дээр ажиллагаанд оруулна
	Эмнэлгийн болон аюултай хог хаягдлын менежментийг хогийн төвлөрсөн цэг дээр гүйцэтгэж 2024 он гэхэд тэрхүү төрлийн хог хаягдлыг зохисгүй, хууль журмаас гадуур байдлаар хаяхыг хориглоно.
	Эмнэлгийн ерөнхий ахуйн хог хаягдлыг (халдваргүй/аюулгүй хог хаягдлыг) сумын дахивар хаягдлын төв дээр хүлээн авч дулааны аргаар устгах болно.
	Эмнэлгийн хог хаягдлын нэгэн адил үйлдвэрийн хог хаягдлыг боловсруулах болон дарж булах, дулааны аргаар устгах төлөвлөгөөг гаргана.
	Үйлдвэрийн болон эмнэлгийн аюултай хог хаягдлыг боловсруулж дарж булах, дулааны аргаар устгах байгууламж байгуулахад шаардлагатай хөрөнгийг баталгаажуулж тэрхүү байгууламжийг барих ажлыг дэмжинэ.
	Хог хаягдлыг боловсруулах болон дарж булах байгууламж бүрэн гүйцэд баригдаж дуустал эх үүсвэр дээр ангилах, хадгалах үйл ажиллагааг нэвтрүүлнэ.
Удирдлага, Хууль эрх зүйн сайжруулалт	Энгийн хог хаягдлын журмыг батлуулах
	ААН, байгууллагуудад хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах байх тухай заах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг өөрсдийн хөрөнгөөр шийдэх
	ААН, байгууллагуудад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл зайлшгүй хог хаягдлын тээвэрлэлтийг гэрээг зохих зөвшөөрөл бүхий байгууллага хийж гүйцэтгэхийг шаардах

Зорилт	Хийгдэх ажлууд
	Одоогийн мөрдөгдөж байгаа ялган ангилаагүй тээвэрлэлтийг тарифыг ихэсгэх. Энэ нь ААН, байгууллагуудыг аль болох бага хаягдал гаргахын эрмэлзэх мөн хог хаягдлаа ангилж хаяхад маш хүчтэй түлхэц болно.
	Сумын түвшинд хог хаягдлын менежментийн байнгын хяналт болон мэдээллийн тогтолцоог байгуулна. Юуны түрүүнд, өртөг/ашиг, өртөг/үр ашиг, өртөг/үр өгөөжийн үнэлгээг хийх зорилгоор үйл ажиллагааны зардлыг тодорхойлохын зэрэгцээ хог хаягдлын менежменттэй холбоотой мэдээллийн баазыг байгуулж төрийн болон хувийн секторын цэвэрлэгээний үйлчилгээний ажлын чанар ба өртгийг байнга шалгаж байх боломжтой болно.
	Аймаг сумын хэмжээнд хог хаягдлын үйлчилгээний санг байгуулж хогны төлбөрийг хураах менежмент хийх зохистой тогтолцоог бий болгоно. Хогны үйлчилгээний санг нээлттэй, шударга байдлаар менежмент хийхийн тулд аймаг болон сумын хэмжээнд мэдээллийн бааз байгуулна
ДУНД ХУГАЦААНД САЙЖРУУЛАХ	
Эх үүсвэр дээр ангилан ялгах 2	2024 он гэхэд орон сууцны хорооллын нийт оршин суугчдын 100%-ийг хог хаягдлыг ангилан цуглуулах тогтолцоонд өргөжүүлэн хамруулна. Ялган ангилах төслийн үйл ажиллагааг тогтмолжуулах
	Анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлын хэмжээг багасгах үйл ажиллагааг дэмжиж хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулалт хийх, түүхий эд болгох үйл ажиллагааг орон нутгийн удирдлагын зүгээс дэмжих Ялган ангилалт хийхгүй байгаа айл өрхүүдтэй хариуцлагын тогтолцоог бий болгох. Ялган ангилалт хийгээгүй айл өрхийг торгодог болгох, ялган ангилж байгаа иргэдийг хогны төлбөрөөс чөлөөлөх системийг бий болгож хяналтыг сайжруулах
Эмнэлгийн болон үйлдвэрийн аюултай хог хаягдлын аюулгүй устгах	Үйлдвэрийн аюултай болон эмнэлгийн хог хаягдлыг хууль журмын дагуу боловсруулж дарж булаах болно. Аюултай эмнэлгийн болон үйлдвэрийн хог хаягдлыг тусгай зориулалтаар баригдсан байгууламж, хогийн цэг дээр боловсруулж дарж булаах, дулааны аргаар устгах үйл ажиллагааг гүйцэтгэх
Хувийн хэвшилтэй хамтран ажиллах, дэмжих	Аймаг сумын хог хаягдал болон аюултай болон үйлдвэрийн хог хаягдал хариуцах байгууллагуудын захиргаа, менежментийн чадавхыг бэхжүүлэн сайжруулах Хог хаягдлын тухай хуульд заасан Үүсгэгч нь хариуцах тухай заалтаар тухай хог хаягдлыг үүсгэгчид хог хаягдлын устгалын зардлыг хариуцуулах журмын заалтыг оруулах
	Айл өрхүүдээс авах хог хаягдлын төлбөрийг их хэмжээгээр нэмэгдүүлэх. Ялган ангилж хаясан иргэдийг төлбөрөөс чөлөөлөх эсвэл урамшуулах системийг нэвтрүүлэх.
	Хувийн хэвшлийн компаниудын оролцоог цаашид ч дэмжиж илүү үр ашигтай, хямд зардалтай хатуу хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх
	Хувийн компанийн ажилчдыг оролцуулан хог хаягдлын менежменттэй холбоотой боловсон хүчнийг сургалт, тусгай мэргэжлийн сургалт дамжааны хөтөлбөрт хамруулах шаардлагатай. Хог хаягдлын менежментийн төхөөрөмж, байгууламжийн үйл ажиллагааг хариуцах хүмүүсийн мэдлэг чадварыг үнэлэх зорилгоор ажлын байрны мэргэшил чадварыг бий болгох хэрэгтэй.
	Эзлэхүүнд суурилсан тээвэрлэлтийг үнэ тариф тогтоох

Зорилт	Хийгдэх ажлууд
Хог хаягдал цуглуулах тогтолцоог сайжруулах 2	<p>Ангилан цуглуулах болон хаягдал түүхий эд цуглуулах болон дахин боловсруулах үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх зорилгоор олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд нийтийн боловсрол, сурталчилгааны кампанит ажлыг гүйцэтгэх хэрэгтэй</p> <p>Хог хаягдлын цуглуулах салбарт ажиллах байгаа ЖДҮйлдвэрлэгч нарын аймгийн хог хаягдлын сангаас дэмжих. Хог хаягдлын дахин ашиглалт, дахин боловсруулж байгаа иргэн, ААН -ийг дэмжсэнээр ЭЗ-ийн хувьд тогтвортой байдал бий болж тэдний үйл ажиллагаа тогтворжиж хог хаягдлаа цуглуулах үйл ажиллагааг тогтмол, тасалдалгүй хийх боломж үүснэ.</p>
Дахин боловсруулалтыг дэмжих	<p>Дахин боловсруулах боломжит үйлдвэрлэлүүдийг байгуулах, дэмжих</p> <p>Хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах чиглэлд ажиллах байгаа иргэдийг эдийн засгийн хувьд дэмжсэнээр дахин боловсруулалтыг үйл ажиллагаа тогтвортой болж Улаангом сумаас хаягдаж байгаа хаягдал багасна.</p>
УРТ ХУГАЦААНД БАРИМТЛАХ БОДЛОГО	
Удирдлага зохион байгуулалтыг сайжруулах	Орон нутгийн оролцоотой үйл ажиллагааг дэмжих тогтолцоог бүрэн гүйцэд байгуулж Мастер төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлнэ.
	Нэгдсэн хогийн цэгийг ашиглах боломжтой хугацааг тодорхой дараагийн шинэ хогийн төвлөрсөн цэгийг сонгох урьдчилсан судалгаа, ТЭЗҮ судалгаа болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан судалгаа зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ. Шинэ хогийн төвлөрсөн цэг байгуулах нарийвчилсан зураг төсөл болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвлөн баталгаажуулна. Шинэ хогийн төвлөрсөн цэг байгуулж, хүнд даацын машин механизм, машин техник, тоног төхөөрөмж худалдаж авна.
Олон нийтийн идэвхжүүлэх	Дахин боловсруулалт хийдэг нийгмийн тогтолцоо бий болгохын тулд нийтийн боловсрол, сурталчилгааны кампанит ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж олон нийтийн хамтын ажиллагааг дэмжинэ.
Боловсролоор олон нийтэд хүрэх	Цэцэрлэг болон ЕБС-ийн нийгмийн ажилтнуудыг хог хаягдлыг сургагч багшаар бэлтгэж
	Хүүхдийн насны онцлогт тохиорсон хог хаягдлыг ялган хаяхын ач тусыг ойлгуулсан сургалт, сурталчилгаа, үхуулах үйл ажиллагааг зохион байгуулж, ухамсарт суулгах
	Хүүхдийн багаас нь хог хаягдал зөв харьцах, ялган хаях дадлыг сургах зорилготой тоглоомууд, comics ном, сургалтын хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлэх
	Хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн чиглэлийн төрийн бус байгууллагуудтай өргөн хүрээгээр хамтран ажиллах

5 ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1 БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

1. Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглалтыг хөхүүлэн дэмжих;
2. Хог хаягдлыг байгаль орчинд хал багатай арга технологиор устгах;
3. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулах;
4. Үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг тухайн үүсгэгчээр нь хариуцуулах, бохирдуулагч нь төлбөр төлөх;
5. Иргэд, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, түншлэлд тулгуурлах;
6. Гадаад орны хог хаягдлын менежментийн тэргүүн туршлагыг аймгийнхаа онцлогт тохируулан бүтээлчээр нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

5.2 ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Богино хугацааны зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1. Хог хаягдлын тухай хуульд заасан тодорхой эрх, үүрэг бүхий албан тушаалтануудын оролцоог сайжруулах, чадавхжуулах
2. Хог хаягдлын тухай хууль, журмын хэрэгжилтийн талаар хяналт шалгалтыг эрчимжүүлэх
3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг нэмэгдүүлэх
4. Хог хаягдлын тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж, орчны бохирдлыг хяналтыг сайжруулах
5. Зохисгүй байдлаар хог хаях байдлыг арилгах
6. Олон нийтийг хамарсан сурталчилгаа, ухуулах үйл ажиллагааг гүйцэтгэх
7. Дахиврын тээврийн менежментийг сайжруулах
8. Дахин ашиглах боломжтой шилэн лонхыг худалдааны төвүүдээр дамжуулан эргүүлэн авч, урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ.
9. Аюултай хаягдлын тооллого явуулах

Дунд хугацааны зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1. Үйлдвэрлэл, үйлчилгээний хог хаягдлын зохистой менежментийг бий болгож, хаягдалгүй, байгальд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлэхэд дэмжиж, хяналт, хариуцлагыг сайжруулна.
2. Томоохон үйлдвэрлэгч, үйлчилгээний газруудыг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй болгох
3. Ахуйн аюултай хаягдлыг зүй зохистой хаядаг тогтолцоонд шилжих /цахим төхөөрөмж, аккумулятор, дугуй, малын сэг зэм/
4. Хог хаягдлыг дахин боловсруулах Дахивар хаягдлын төвийг байгуулахад төр хувийн хэвшил хамтран ажиллана.
5. Эх үүсвэр дээр нь хогийг ангилан ялгаж хаях хогийн савыг нэвтрүүлж, ангилсан хог хаягдлыг тусд нь цуглуулан тээвэрлэдэг тогтолцоог бүрдүүлэх
6. Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт байгальд сөрөг нөлөө багатай технологи нэвтрүүлэх
7. Барилга, эрүүл мэнд, ХАА, дулаан, үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг сайжруулах
8. Хог тээврийн машин техникийн хүрэлцээг сайжруулна.

9. Хог хаягдлын менежмент хөгжсөн улс орнуудын туршлага нэвтрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх
10. Хог хаягдлын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН, ЖДҮйлдвэрлэгч нарын аймгийн хог хаягдлын сангаас дэмжих
11. Эмнэлгийн болон Аюултай хог хаягдлыг хяналттай болгож, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах

Урт хугацааны зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1. ЕБС-иар дамжуулан тогтвортой хөгжлийн боловсрол болон хог хаягдлын талаарх зөв дадлыг эзэмшүүлнэ.
2. Мэргэжлийн багш, зөвлөхүүдтэй хамтран сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш, бага ангийн багш нарыг чадавхжуулж, хүүхдэд байгаль орчны боловсрол олгоход хамтран ажиллана.
3. Хэвлэл мэдээллийн байгууллага болон сургалтаар дамжуулан олон нийтэд хог хаягдлын талаар мэдлэг өгнө.
4. Олон нийтийн компанит ажил, 3R зарчмын үйл ажиллагаанд залуу үеийнхэн, ТББ-ыг татан оролцуулах
5. Хөдөөгийн малчдын хог хаягдалтай зөв харьцах дадал, мэдлэгийг олгох, хэрэгжүүлэх
6. Олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлж, зөв дадал, сэтгэлгээг төлөвшүүлэх, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх
7. Хүүхдийн насны онцлогт тохиорсон хог хаягдлыг ялган хаяхын ач тусыг ойлгуулсан сургалт, сурталчилгаа, ухуулах үйл ажиллагааг зохион байгуулж, ухамсарт суулгах

5.3 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Арга зам	Шалгуур үзүүлэлт		Санхүүжилт		Хугацаа	Зохион байгуулагч	
			Хэмжих нэгж	Хүрэх үр дүн	Хэмжээ /сая.төг/	Эх үүсвэр		Үндсэн	Хамтрагч
БОГИНО ХУГАЦААНЫ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
1.1	Хог хаягдлын тухай хуульд заасан тодорхой эрх, үүрэг бүхий албан тушаалтнуудын оролцоог сайжруулах, чадавхжуулах	Сум, Багийн Засаг дарга, байгаль хамгаалагч, олон нийтийн байцаагчийн үр дүнгийн гэрээ, ажлын төлөвлөгөөнд тодорхой ажлыг тусгаж, дүгнэдэг болох	Тусгасан үйл ажиллагаа	Холбогдох албан тушаалтнуудын оролцоо нэмэгдэж, чадавхажсан байна.			2022-2024	Сумын ЗДТГ, байгууллагын дарга нар	БОАЖГ
1.2		Холбогдох албан тушаалтан, иргэдийн бүлгийг чадавхжуулах сургалт зохион байгуулна.	Сургалтын тоо	1-ээс доошгүй удаа сургалт хийж, холбогдох албан тушаалтнуудын мэдлэг дээшилнэ.	5,0	ОНТ	2022-2023	БОАЖГ	АЗДТГ
1.3	Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, дахин боловсруулах, дахин ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, иргэдийн бүлэг, аж ахуйн нэгжийг дэмжих	Сумын төв болон аймгийн төвийн баг бүр дээр хог хаягдлыг ангилах, цуглуулах, боловсруулах, ашиглах иргэдийг дэмжинэ.	Дэмжлэг авсан иргэдийн тоо	Хог хаягдлыг салбарт ажиллах иргэдийн тоо өснө		ОНТ, ХХ Хураамжийн орлого	2022-2023	Сум, багийн Засаг дарга	ТББ, Иргэдийн бүлэг
1.4	Энгийн хог хаягдлын журам батлуулах	Хог хаягдлын тухай хуулийн дагаж мөрдөж журмыг аймгийн хэмжээнд гаргаж баталгаажуулах	Журамтай болох				2022	ИТХ	АЗДТГ БОАЖГ ТББ
1.5		ААН-үүдээс авах ялган ангилаагүй хог хаягдлын тээврийн үнийг эрс нэмэгдүүлэх	Нэгдсэн хогийн цэгийн ачилтын тоо	Хог хаягдлаа ялган ангилах эрмэлзэлтэй болно. ХХ-аас орж ирэх орлого нэмэгдэнэ.			2022	Сумын Засаг дарга	АЗДТГ БОАЖГ ТББ
1.6		Эзлэхүүнд суурилсан хог тээврийн тариф мөрдүүлэх					2024-2026	Сумын Засаг дарга	АЗДТГ БОАЖГ ТББ
1.7		ААН, байгууллагуудыг хог хаягдлаа ялган ангилахыг журмаар шахах, хяналт тавих	ААН өөрийн хөрөнгөө хийсэн Ялган ангилах савны тоо	ААН, байгууллагууд ялган ангилах боломжтой болно. Ялган ангилж эхэлнэ			2022-2023	Сумын Засаг дарга	МХГ БОАЖГ ААН
1.8	Хог хаягдлын тухай хууль, журмын хэрэгжилтийн талаар хяналт шалгалтыг эрчимжүүлэх	Жил бүрийн хяналт шалгалт, авсан арга хэмжээний мэдээллийг нэгтгэж, мэдээллийн сан бүрдүүлнэ. МХГ, Цагдаа, олон нийтийн цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагчийн оролцоог нэмэгдүүлэх	Хяналт шалгалт, торгуулийн тоо хэмжээ	Иргэдийн хариуцлага нэмэгдэж, зөрчил буурсан байна.			2022-2029	МХГ, Цагдаагийн газар	Сум, багийн Засаг дарга, ОНЦагдаа

	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Арга зам	Шалгуур үзүүлэлт		Санхүүжилт		Хугацаа	Зохион байгуулагч	
1.9	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг нэмэгдүүлэх	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоож, хог хаягдлын орлогыг төсөвт төвлөрүүлнэ.	Төвлөрүүлсэн хураамжийн хэмжээ	Хураамжийн хэмжээг нэмэгдүүлснээр хог хаягдалд зарцуулах мөнгө нэмэгдэнэ.			2022	Сумын Засаг дарга	АЗДТГ, БОАЖГ
1.10		Үйл ажиллагаа явуулж байгаа бүхий ААН, байгууллагуудтай хог хаягдлыг тээвэрлэлтийн гэрээг байгуулж орлогоо нэмэгдүүлэх	Төвлөрүүлсэн хураамжийн хэмжээ	Хог хаягдлаа ялган ангилж хаях хөшүүрэг болно, орлого төвлөрүүлэлт нэмэгдэнэ			2022	Сумын Засаг дарга	АЗДТГ
1.11		Нэгдсэн хогийн цэг дээр төлбөртэйгөөр хаягдал буулгах боломжийг бий болгох	Төвлөрүүлсэн хураамжийн хэмжээ	Нэмэлт орлогын эх үүсвэртэй болно	40,0	ОНТ	2022	ТҮК, СЗДТГ	АЗДТГ
1.12		ТҮК машин механизмыг GPS системээр хянах, замчлах	Төвлөрүүлсэн хураамжийн хэмжээ	Шатахууны илүү зардлыг хэмнэх, зөвшөөрөлгүй тээврийг хязгаарлана	15,0	ОНТ	2022	ТҮК, СЗДТГ	
1.13	Хог хаягдлын тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж, орчны бохирдлыг хяналтыг сайжруулах	Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж орчны бохирдлыг мэдээлэх, бүртгэлжүүлдэг болгох, урамшуулдаг болгох	Замбараагүй хаягдлын тоо буурна	Тээвэрлэлт сайжирч, орчны бохирдол буурна	5,0	ОНТ	2022-2013	ТҮК, СЗДТГ	Сум, багийн Засаг дарга, ОНЦагдаа
1.14	Зохисгүй байдлаар хог хаях байдлыг арилгах	Ил задгай газар хог хаях явдлыг хянахын тулд иргэдийн оролцоог сайжруулах, урамшуулах	Нэгдсэн хогийн цэгт бууж байгаа хаягдлын хэмжээ	Зохисгүй байдлаар хог хаях байдал багасна	25,0	ОНТ	2022-2024	БОАЖГ, СЗДТГ	Сум, багийн Засаг дарга, ОНЦагдаа
1.15		Замын хяналтын камерын системийг ашиглах, ТҮК тээврийн машинуудыг GPS системээр хянадаг болгох	Нэгдсэн хогийн цэгт бууж байгаа хаягдлын хэмжээ	Зохисгүй байдлаар хог хаях байдал багасна	15,0	ОНТ	2022-2023	ТҮК, МХГ, Цагдаагийн газар	ОНЦагдаа
1.16	Олон нийтийг хамарсан сурталчилгаа, ухуулах үйл ажиллагааг гүйцэтгэх	Хог хаягдлаа ялган хаях, зохистой хаях талаар олон нийт рүү чиглэсэн ухуулах, сурталчлах ажиллагаа	ДХТ рүү буулгаж байгаа дахивар хаягдлын хэмжээ	Олон нийт эерэг, байгаль ээлтэй амьдралын хэв маягтай болно	75,0	ОНТ	2022-2024	БОАЖГ	ТББ-ууд, Сум, багийн Засаг дарга, ОНЦагдаа
1.17	Дахиврын тээврийн менежментийг сайжруулах	Зөвхөн дахивар хаягдал цуглуулах үйл ажиллагааг гүйцэтгэх хувийн хэвшлийг бий болгох	ДХТ рүү буулгаж байгаа дахивар хаягдлын хэмжээ	Дахивар хаягдлыг тээвэрлэлт хийх нэгжтэй болно. Дахин ашиглалт, дахин боловсруулалт хийх нөхцөл бүрдэнэ			2022	СЗДТГ БОАЖГ	Хувийн хэвшил, ТҮК
1.18		Дахивар тээврийг төлбөргүйгээр тээвэрлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	ДХТ рүү буулгаж байгаа дахивар хаягдлын хэмжээ	ААН, байгууллагууд хаягдлаа ялгах дахивраа үнэгүй тээвэрлүүлэхийг эрмэлзэнэ	10,0	ОНТ	2022	СЗДТГ	АЗДТГ

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Арга зам	Шалгуур үзүүлэлт		Санхүүжилт		Хугацаа	Зохион байгуулагч	
		Эзлэхүүнд суурилсан төлбөрийн тээврийн системийг нэвтрүүлэх	Орлогийн хэмжээ, рейсийн тоо	Их овортой хог үүсгэгч тэр хэмжээгээрээ төлбөрөө төлнө			2024-2025	СЗДТГ	АЗДТГ
1.19	Дахин ашиглах боломжтой шилэн лонхыг худалдааны төвүүдээр дамжуулан эргүүлэн авч, урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ.	Үйлдвэрлэгч, импортлогч, гэрээт борлуулагч, үйлдвэрлэгч нь тодорхой төрлийн хаягдлаа эргүүлэн татдаг тогтолцоонд шилжинэ.	Эргүүлэн цуглуулсан хаягдлын хэмжээ	Байгальд шингэж, устдаггүй хаягдлын хэмжээ буурна.			2022-2023	ААНБ-ууд	АЗДТГ, БОАЖГ, МХГ, сумын ЗДТГ
1.20	Аюултай хаягдлын тооллого явуулах	Аюултай хаягдлын эх үүсвэрийг бүртгэлжүүлж, хяналттай болгох ажлыг давтамжтай хийх	Аюултай хаягдлын хяналттай цэгийн тоо	Аюултай хаягдлыг зөвшөөрөлтэй цэгт хаягддаг болгоно.	5,0		2022-2023	Сумын ЗДТГ	БОАЖГ, МХГ
ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
2.1	Үйлдвэрлэл, үйлчилгээний хог хаягдлын зохистой менежментийг бий болгож, хаягдалгүй, байгальд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлэхэд дэмжиж, хяналт, хариуцлагыг сайжруулна.	Үйлдвэрлэл, үйлчилгээний хаягдлыг дахин ашиглах, боловсруулах туршлагыг нэвтрүүлэхэд бодлогоор дэмжинэ, /барилгын, хүнсний хаягдал, яс, баглаа боодол, гялгар уут г.м/	Үйлдвэрлэл, үйлчилгээний тоо	Байгальд хаягдах хогны хэмжээ буурч, ажлын байр нэмэгдэнэ.			2022-2026	ААНБ, үйлчилгээний газрууд, иргэд	Сумын ЗДТГ, ГХБХБГ, БОАЖГ, УХААГ
2.2	Томоохон үйлдвэрлэгч, үйлчилгээний газруудыг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй болгох	Томоохон ХҮТ, үйлдвэрлэгчид, үйлчилгээний газрууд хог хаягдлын төлөвлөгөөг холбогдох байгууллагаар хянуулдаг болно.	Төлөвлөгөө хэрэгжүүлэгч байгууллагын тоо	Үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарч буй хогны хэмжээ буурна.			2022-2026	ААНБ-ууд	БОАЖГ, МХГ,
2.3	Ахуйн аюултай хаягдлыг зүй зохистой хаядаг тогтолцоонд шилжих /цахим төхөөрөмж, аккумулятор, дугуй, малын сэг зэм/	Ахуйн аюултай хаягдлын талаар холбогдох байгууллага, иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, халдваргүйжүүлэх, аюулгүй цуглуулалт, тээвэрлэлтийг дэмжинэ	Аюултай хаягдлыг цуглуулах, тээвэрлэх тогтолцоо	Ахуйн аюултай хаягдлаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө буурна.		ОНТ	2023-2026	АЗДТГ, БОАЖГ	МХГ, ЭМГ, ААН, ТББ-ууд
2.4	Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг Дахивар хаягдлын төвийг байгуулахад төр хувийн хэвшил хамтран ажиллана.	Төсөл бичих, ТЭЗҮ боловсруулах, төсөл, хөтөлбөрт хамруулахад төрийн байгууллагын зүгээс хамтран ажиллана. Төслийн санхүүжилт олох ажлыг зохион байгуулах	Төслийн үе шат	Цогц байдлаар байгуулсанаар хогийг цуглуулах, ангилах, боловсруулах үйл ажиллагаа жигд явагдана.	ТЭЗҮ-ээр	Зээл, төсөл	2022-2026	АЗДТГ, БОАЖГ, сумын ЗДТГ	ААН, иргэн, ТББ-ууд
2.5	Эх үүсвэр дээр нь хогийг ангилан ялгаж хаях хогийн савыг нэвтрүүлж, ангилсан хог хаягдлыг тусд нь цуглуулан тээвэрлэдэг тогтолцоог бүрдүүлэх	Аймгийн төвийн орон сууц, нийтийн эзэмшлийн талбай, гэр хорооллын айл өрхөд ялган ангилах хогийн савны загварыг сурталчилж, төсвийн хөрөнгөөр хийж байрлуулах	Хогийн савтай болсон өрхийн тоо	Хог хаягдлыг гудамжинд асгадаг, ангилдаггүй байдлыг бууруулна.	4 тэрбум	ОНТ	2022-2026	АЗДТГ, БОАЖГ сумын ЗДТГ	Иргэн, ААНБ, ТББ-ууд
2.6	Ялган ангилсан хог хаягдлын тээвэрлэлтийг тогтолцоог бий болгох	Дахивар хаягдлыг тээвэртэй болох	Дахивар хаягдлыг тээвэртэй болох	Нэгдсэн хогийн цэгт бууж байгаа хогийн хэмжээ эрс буурна	100 сая	ОНТ	2022-2026	АЗДТГ, БОАЖГ сумын ЗДТГ	Иргэн, ААНБ, ТББ-ууд

	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Арга зам	Шалгуур үзүүлэлт		Санхүүжилт		Хугацаа	Зохион байгуулагч	
			Хогийн цэгийн ангилал	Хогийн цэгээс орчинд үзүүлэх нөлөө буурна.	ТЭЗҮ-ээр	ОНТ, төсөл		Сумын ЗДТГ	АЗДТГ, БОАЖГ
2.7	Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт байгальд сөрөг нөлөө багатай технологи нэвтрүүлэх	Шинээр хог асгах цэгийг хуулийн шаардлагад нийцсэн 2-р зэргийн ландфилл болгох төсөл бичиж, хөрөнгө санхүүг шийдэх	Хогийн цэгийн ангилал	Хогийн цэгээс орчинд үзүүлэх нөлөө буурна.	ТЭЗҮ-ээр	ОНТ, төсөл	2023-2027	Сумын ЗДТГ	АЗДТГ, БОАЖГ
2.8	Барилга, эрүүл мэнд, ХАА, дулаан, үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг сайжруулах	Эдгээр салбаруудаас гарах хог хаягдлыг зохистой хаях, ашиглах, дахин боловсруулах, устгах журмыг хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Эрүүл мэнд, барилга, дулааны болон бусад үйлдвэрлэл, ХАА-н хог хаягдлын ашиглалт, устгалт сайжирна.		Улсын болон ОНТ	2023-2025	ГХБХБГ, ЭМГ, ХХААГ, ДС	АЗДТГ, холбогдох яамд, БОАЖГ,
2.9	Хог тээврийн машин техникийн хүрэлцээг сайжруулна.	Аймгийн төвд хог тээврийн зориулалтын машины тоог нэмэгдүүлнэ.	Зориулалтын тээврийн хэрэгслийн тоо	Хог тээврийн ажиллагаа үр дүнтэй болно.	450,0	ОНТ	2022-2025	Сумын ЗДТГ	АЗДТГ
2.10	Хог хаягдлын менежмент хөгжсөн улс орнуудын туршлага нэвтрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хог хаягдлын менежментээр дээгүүрт ордог улсад туршлага судлах, сайн дурын ажилтан авч ажиллуулах талаар судалж, шийдвэрлэнэ.	Үйл ажиллагаагаар	Дэвшилтэт санал санаачилга нэвтрүүлсэн байна.			2022-2027	ИТХ, АЗДТГ,	БОАЖГ, сумын ЗДТГ
2.11	Хог хаягдлын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН, ЖДҮйлдвэрлэгч нарын аймгийн хог хаягдлын сангаас дэмжих	Хог тээвэр, цуглуулалт, дахин боловсруулалт, дахин ашиглалт чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН-ийг урамшуулах, дэмжих	Ланфилл хог хаягдлын хэмжээ багасна	ЭЗ-ийн хувьд тогтвортой ААН, иргэд өөрсдөө хог хаягдлаа устгах ажлыг хийнэ	500,0		2023-2026	АЗДТГ, СЗДТГ, БОАЖГ	
2.12	Эмнэлгийн болон Аюултай хог хаягдлыг хяналттай болгож, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах	Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлыг сар бүр аюулгүй тээвэрлэх автомашин ариутгах автоклавтай болгож, хувийн ААН болон ТҮК-д нэгж байгуулж гүйцэтгүүлэхийг дэмжинэ.	Зориулалтын байгууламжийн тоо	Эмнэлгийн био аюултай хаягдал хяналттай болно.	70,0	ОНТ, төсөл хөтөлбөр	2022-2026	Сумын ЗДТГ, ЭМГ	АЗДТГ
2.13		Аюултай хог хаягдлыг сар бүр аюулгүй тээвэрлэж, устгах	Зориулалтын техник, байгууламжийн тоо	Аюултай хаягдал хяналттай болно	50,0	ОНТ, төсөл хөтөлбөр	2022-2026	Сумын ЗДТГ,	АЗДТГ
2.14		Эмнэлгийн болон Аюултай хог хаягдлыг дулааны аргаар устгах зүүхтэй болох	Дулааны аргаар устгах байгууламжтай болох	Байгаль халгүй устгах байгууламжтай болно		ОНТ, төсөл хөтөлбөр	2022-2024	Сумын ЗДТГ,	АЗДТГ

	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Арга зам	Шалгуур үзүүлэлт	Санхүүжилт	Хугацаа	Зохион байгуулагч			
УРТ ХУГАЦААНЫ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
3.1	ЕБС-иар дамжуулан тогтвортой хөгжлийн боловсрол болон хог хаягдлын талаарх зөв дадлыг эзэмшүүлнэ.	Эко сургууль болон ЕБС-ийн эко бүлгийг чадавхжуулж, сургуулийн нийгмийн ажилтан, цаашилбал сургалтын хөтөлбөрт хог хаягдалтай зохистой харьцах талаар оруулан олон нийтийн идэвх санаачилгыг өрнүүлэх, мэдээлэл түгээх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих	Үйл ажиллагааны үр дүнгээр	Хог хаягдлын талаарх дадал өөрчлөгдсөн байна.	18,0	ОНТ, төсөл хөтөлбөр	2023-2030	Аймаг, сумдын ЗДТГ, БСУГ, БОАЖГ	ТББ-ууд, ЕБС-иуд, ААН, Иргэд
3.2	Мэргэжлийн багш, зөвлөхүүдтэй хамтран сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш, бага ангийн багш нарыг чадавхжуулж, хүүхдэд байгаль орчны боловсрол олгоход хамтран ажиллана.	Бага ангийн болон СӨБ-ын багш нарыг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх зэргээр хог хаягдлын талаарх мэдлэг, дадлыг хүүхдэд эзэмшүүлнэ.	Багш нарын үйл ажиллагаагаар	Хүүхдэд багаас нь хог хаягдлын талаар зөв дадал эзэмшүүлнэ	5,0	ОНТ	2023-2030	БСУГ	БОАЖГ, ТББ-ууд
3.3	Хэвлэл мэдээллийн байгууллага болон сургалтаар дамжуулан олон нийтэд хог хаягдлын талаар мэдлэг өгнө.	Зорилтот мэдээ, нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэх	Нэвтрүүлгийн тоо давтамж	Олон нийтийн мэдлэг дээшилнэ	10,5	ОНТ	2023-2030	БОАЖГ	Сумын ЗДТГ
3.4	Олон нийтийн компанит ажил, ЗР зарчмын үйл ажиллагаанд залуу үеийнхэн, ТББ-ыг татан оролцуулах	Насан түршийн боловсролын багш, бэлтгэгдсэн сургагч багш, ТББ, сайн дурын клубуудыг оролцуулах	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Олон нийт, залуучуудын оролцоо, хандлага өөрчлөгдөнө.	24,0	ОНТ	2023-2030	Аймаг, сумын ЗДТГ,	БОАЖГ, ТББ, олон нийтийн байгуул агууд
3.5	Хөдөөгийн малчдын хог хаягдалтай зөв харьцах дадал, мэдлэгийг олгох, хэрэгжүүлэх	Малчдад мэдээлэл өгч, ойролцоох газруудыг хариуцуулан хог хаягдлыг цэвэрлүүлж хэвших	Малчдын үйл ажиллагаа	Хөдөөгийн малчдын нутагладаг газрууд хог хаягдалгүй болно	15,0	ОНТ	2023-2030	Сумын ЗДТГ	
3.6	Олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлж, зөв дадал, сэтгэлгээг төлөвшүүлэх, боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх	Өргөн дэлгэцийн ТВ-үүд, social сүлжээ, цэцэрлэг, ЕБС -уудаар урьдчилан бэлдсэн контентыг цацаж дадал, зуршлыг хэвшүүлэх	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Хог хаягдлын талаарх дадал өөрчлөгдсөн байна	12,0	ОНТ	2023-2030	Аймаг, сумын ЗДТГ	ТББ-ууд, ЕБС-иуд, ААН, Иргэд
3.7	Хүүхдийн насны онцлогт тохиорсон хог хаягдлыг ялган хаяхын ач тусыг ойлгуулсан сургалт, сурталчилгаа, үхүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, ухамсарт суулгах	Цэцэрлэг, ЕБС-ын бага, дунд, ахлах ангийн хүүхдүүд рүү чиглэсэн насны онцлогт тохирсон контент (зурагт ном, үлгэр, сэртүүл, богино хэмжээний хүүхэлдэйн кино, тоглоом гэх мэт) -ийг бэлтгэх	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Хог хаягдлын талаарх дадал өөрчлөгдсөн байна	35,0	ОНТ	2023-2030	Аймаг, сумын ЗДТГ	ТББ-ууд, ЕБС-иуд, ААН, Иргэд

6 ЗУРГАА. САНХҮҮЖИЛТ

Төлөвлөгөөний санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

1. Улсын болон орон нутгийн төсөв;
2. Хог хаягдлын үйлчилгээний хураамж;
3. Олон улсын байгууллага, хандивлагчийн зээл, тусламж;
4. Аж ахуйн нэгж, байгууллагаас гаргах хөрөнгө;
5. Бусад эх үүсвэр.

7 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

7.1 ЭХ ҮҮСВЭР ДЭЭР ЯЛГАН АНГИЛАХ



Энгийн хаягдал нь хүн байгаа газраас тогтмол тодорхой хэмжээгээр байнга үүсэж байдаг.

Монгол орны хэмжээнд хог хаягдлын талаарх эрх зүйн орчин тодорхой хэмжээний хөгжилд хүрсэн гэж мэргэжлийн байгууллагын хувьд үзэж байна. Энэ нь Хог хаягдлын тухай хууль, Ногоон хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр зэргээс бид тод харж болно. Эдгээр хуулийн заалтууд болон үндэсний хэмжээний хөтөлбөрүүд дээр орон нутгийн хэмжээнд хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх, хөтөлбөр боловсруулах, орон нутгийн хэмжээнд эрхзүйн орчныг бүрдүүлэх буюу аймаг тус бүр журам батлах зэрэг үндсэн ажлуудаас гадна хог хаягдлыг ангилж хаях, дадал бий болгох заалтууд багтсан байна.

Дээр дурдсан бодлогын баримт бичиг болон хуулийн хүрээнд суурьшлын бүсэл дараах байдлаар хог хаягдлыг ангилна гэж заасан байна. Үүнд:

Гэр хорооллын айл өрхүүд, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг хамгийн багадаа дараах төрлөөр ангилна.

1. Дахивар / цаас, хуванцар, лааз, гялгар уут/
2. Хүнсний хаягдал
3. Үнс
4. Аюултай хог хаягдал
5. Бусад

Орон сууц хороололд амьдарч байгаа иргэд болон албан байгууллагууд ажиллах хүний тоо, барилгын ашиглалт, үйл ажиллагааны чиглэл зэргийг харгалзан үзэж энгийн хог хаягдлыг хамгийн багадаа дараах үндсэн 4 төрлөөр ангилах нь зохимжтой гэж үзэж байна.


1. Дахивар хаягдал /хуванцар, шил, гялгар уут, цаас/
2. Хүнсний хаягдал
3. Аюултай хог хаягдал
4. Бусад гэсэн үндсэн 4 төрөлд хувааж болно.

Мөн эдгээр хог хаягдал нь тухай өрх, албан байгууллагын ямар үйл ажиллагаа явуулж буй, хэдий хэмжээний хог хаягдал үүсэх боломжтойгоос шалтгаалан тус бүр дээр хогийн савны хэмжээ, хэдэн ангилалтай байх нь өөр хоорондоо адилгүй байж болно.

7.1.1 ГЭР ХОРООЛОЛД ХОГ ХАЯГДЛЫГ ЯЛГАН АНГИЛАХ НЬ

Туршилтаар болон нэгдсэн байдлаар гэр хорооллын айл өрхөд ялган ангилах савыг байршуулж дахивар хаягдал, үнс, бусад хаягдал /шаардлагатай тохиолдолд ангиллын тоог нэмэх/ гэж ялган ангилах нөлөөллийн ажлыг айл өрхүүдэд хийж хог хаягдлаа ангилж хэвшүүлэх, үр дүнтэй ажлыг хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн байгууллагатай хамтран үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулах шаардлагатай.

Тохижилт үйлчилгээний ажилтнуудад ачихад хялбар, өнгө үзэмж сайтай, багадаа 3 ангилал бүхий сав байх.



Зураг 27. Гэр хорооллын айл өрхүүдийн хог хаягдлаа ангилан ялгах хогийн савны жишиг

Монгол орны эрс тэрс нөхцөлд тэсвэртэй, шатахгүй, хугарахгүй төмөр материалаар насжилт өндөртэй ялган ангилах савыг гэр хорооллын айл өрхүүдэд хийж нэвтрүүлэх



7.1.2 ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛД ЯЛГАН АНГИЛАХ НЬ

Аймгийн төвд орон сууцанд амьдардаг 1500 гаруй өрх байгаа. Орон сууцуудын гадаа ялган ангилах сав байрлуулж, айл өрхүүдэд хог хаягдлаа ялган ангилж хэвшүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллах.



Зураг 28. Орон сууц хорооллын гадна байрлан ангиллын савны жишиг зураг

Айл өрхүүд нь хог хаягдлаа гэртээ багадаа 3 ялган ангилж тус тусад нь гялбар уут эсвэл хогийн савандаа хадгална.

1. Дахивар. Хуванцар, цаас, шил, гялгар уут, лааз
2. Хүнсний хаягдал
3. Бусад


Дахивар хаягдлыг саван дах хаягдлуудаа орон сууцны гадаа байрлах ялган ангилах саванд ялган хаяснаар байгаль ээлтэй амьдрах иргэний үүргээ биелүүлж байгаа юм.

7.1.3 АЛБАН БАЙГУУЛЛАГА БОЛОН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙ

Улаангом сумын албан байгууллага болон нийтийн эзэмшлийн талбайд иргэд олон нийтэд хог хаягдлын талаарх мэдээ мэдээллийг хүргэх зорилго бүхий савыг байрлуулан ажилтан албан хаагчдад хог хаягдлаа хэрхэн зөв ялган ангилах, хэвших талаар сургалт сурталчилгааг social сүлжээ, олон нийтийн тв үүдээр явуулж нийтээрээ хог хаягдлаа ялган ангилах аяныг өрнүүлнэ. Тус ангилан ялгах сав нь хог хаягдлаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллүүд, түүнээс үүдэн устаж үгүй болж буй амьтдын бодит зураг зэрэг иргэд олон нийтийг хог хаягдлаа ангилж ялгах сэдэл бий болгох зорилго бүхий мэдээллүүдийг агуулсан сумын гудамж, зам талбай, орчинд өнгө нэмэх ангиллын сав байна.



Зураг 29. Албан байгууллага, нийтийн эзэмшлийн талбайд байршуулах савны загвар



Зураг 30. Нийтийн эзэмшлийн талбай, байршуулах хуванцар, лааз хийх зориулалт бүхий савны загвар

7.2 ХОГ ХАЯГДЛЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Хог хаягдлын тээвэрлэлтүүдийг одоогийн нөхцөл байдалд тулгуурлан нарийн төлөвлөж түүний дагуу ачилт тээвэрлэлтүүд хийгдэх ба цаг тухай бүрд үүсэж буй хог хаягдлын хэмжээ, хэдий хэмжээний хугацаанд сав дүүрч байгаагаас хамааран хуваарьт шинэчлэл хийгдэж байх шаардлагатай.

1. Энгийн хаягдлын тээвэрлэлт.
2. Энгийн бус буюу Аюултай болон бусад хаягдлын тээвэрлэлт. Энэ хаягдлын хувьд тухай хадгалж байгаа савнаас шууд гадагшаа тээвэрлэлт хийнэ. Энэ тухайн хаягдлыг тарах болон нэг дор их хэмжээгээр хадгалах байдлаас сэргийлэх зорилготой юм.

Мөн тээвэрлэлтийн машин ачигч жолоочид тусдаа хэсэг, хэлтэст хамаарагдах буй тухайн ажлын онцлог нөхцөлд тохирсон сургалт, аюулгүй ажиллах зааварчилгаагаар тогтмол хангах шаардлагатай.

7.2.1 ЭНГИЙН ХАЯГДЛЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Энгийн хаягдлын хувьд 2 үе шаттайгаар тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

1. Дахивар хаягдлын тээвэрлэлт
2. Бусад хаягдлыг тээвэрлэлт

7.2.1.1 ДАХИВАР ХАЯГДЛЫН ТЭЭВЭРЛЭЛТ



Тусгай зориулалтын машинаар өдөр бүр, ялган ангилах сав дүүрэх бүрд тээвэрлэлтийг дахивар хаягдлын төв (ДХТ) рүү тээвэрлэнэ.

Тээвэрлэхдээ ялган ангилсан хаягдлаа хооронд нь холихгүйгээр ачилтуудыг гүйцэтгэнэ. Аймгийн хэмжээнд тараан байрлуулсан ялган ангилах сав, байгууллагуудын ачааллыг харгалзан үзэж тодорхой өдрүүдэд дахивар хаягдлаар ялган тээвэрлэдэг зохион байгуулалтад орж болно. Жишээ нь : 2,6 дэх өдөр хуванцар хаягдал, 1,3,5 дах өдөх хүнсний хаягдал, 3 дах өдөр цаас, 4 дэх шил гэдэг ч юм уу.

7.2.1.2 БУСАД ХОГИЙН ЦЭГРҮҮ АЧИГДАХ ТЭЭВЭРЛЭЛТИЙГ

Бусад хогийн цэгрүү ачигдах тээвэрлэлтийг одоогийн хэрэгжиж байгаа зарчмын дагуу ТҮК тээвэрлэнэ.

7.2.2 АЮУЛТАЙ ХАЯГДЛЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Онцгой байгууламжуудаас гарч байгаа хаягдлаас шалтгаалан тухайн хаягдал бүр дээр тээвэрлэлтийн горим өөр өөр байна.

- Галлагаанд ашиглагдсан шатах материалуудаас үүссэн үнсийг тээвэрлэлтийн явцад хийсэж бужигнахааргүй битүү тэвштэй машинд тээвэрлэн хог хаягдлын төвлөрсөн цэгт хаяна.
- Эмнэлгээс гарч байгаа аюултай хаягдлыг тусгай зориулалтын битүүмжилсэн машинаар ээвэрлэнэ
- Аюултай бодисын сав савалгаа, аюултай бодисыг шүүрэлгүй, битүүмжилсэн тээврийн хэрэгслээр аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу тээвэрлэлтийг ажлыг гүйцэтгэж, дулааны аргаар устгана

7.2.3 ДАХИВАР ХАЯГДЛЫН ТӨВ

Энд Улаангом сумаас үүсэж байгаа дахивар хаягдлууд болон аюултай хаягдлууд төвлөрөх бөгөөд эндээс ялгагдан цааш нь дахин боловсруулалт, дахин ашиглалт, дулааны аргаар устгал зэрэгт хуваарилагдана.

Дахивар хаягдлын төв /ДХТ/ дээр ирж байгаа бүхий хаягдлуудыг дараах байдлаар ялган ангилж буулгана.

- Хуванцар
- Цаасан хаягдал
- Хүнсний хаягдал
- Метал хаягдал
- Модон хаягдал
- Хаягдал дугуй
- Аюултай хаягдал
- Тосон хаягдал болон бусад

Тухайн буусан аюултайгаас хаягдлаас дахин боловсруулах боломжтой хаягдлын дахин боловсруулалтад оруулж, орон нутагт дахин боловсруулагдахгүй хаягдлуудыг шахах төхөөрөмжөөр шахан шууд ачилт хийгдэнэ УБ руу тээвэрлэх ажиллагааг удирдан зохион байгуулна.

Мод болон цаасан хаягдлаас тодорхой хэмжээг хүнсний хаягдлын хамт бордооны үйлдвэрлэлд нийлүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.



7.2.4 ЯЛГАН АНГИЛАХ.

ДХТөв дээр ялган буусан хаягдлуудаас ялгалтыг дараах байдлаар гүйцэтгэж дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлнэ.

- Хуванцрыг PET, HDPE, PVC, PP, LDPE төрөл бүрээр
- Лаазыг хөнгөн цагаан болон бусад,
- Цаасыг бор картон болон бусад
- Метал хаягдал
- Тосон хаягдал

Эдгээрээс Ялган ангилах явцдаа хаягдлаа бусад төрлийн зүйлс агуулсан байвал цэвэрлэх, салгах ажлын мөн давхар гүйцэтгэнэ. Агуулагдсан зүйлсээсээ шалтгаалан аюултай эсвэл дахин боловсруулах боломжгүй болсон хаягдлыг мөн ялгаж тухайлсан хаягдлыг төрөлд нийлүүлнэ.



7.2.5 ШАХАЖ НЯГТРУУЛАХ.

ДХТөв дээр суурилуулагдсан шахагч төхөөрөмжөөр ангилж, цэвэрлэсэн дахивар хаягдлуудыг багцалж тээвэрлэхэд бэлдэж хураана. Нэг бүрийн жин 500кг аар ихгүйгээр байхаар багцална.

ДХТөвөөс ирж буй дахивар хог хаягдлыг дахин боловсруулагдах төрөл тус бүрээр нь нягтруулах, овор хэмжээг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулна.





Зураг 31 Дахивар цэгийн жишиг

Ангилан ялгасан дахивар хаягдлуудын овор хэмжээг бууруулан тодорхой хувиарын дагуу дахин боловсруулах үйлдвэрүүдэд /Улаанбаатар/ бэлтгэн нийлүүлнэ.

2019 болон 2020 онд Байгаль очин аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санаачлагаар нийт 21 аймагт 2 жил дараалан хог хаягдлын ангилан ялгах ажлын дэмжих зорилгоор дахивар хаягдлын овор хэмжээг бутлагч пресслэгч, бутлагч төхөөрөмжүүдийг нийлүүлсэн. Тус төхөөрөмжүүд Увс аймгийн БОАЖГ-т хүлээлгэж өгсөн байгаа ба тус төхөөрөмжүүдийг ажиллуулах иргэн, ААН сонгон шалгаруулж ажиллагаанд оруулах шаардлагатай.



Зураг 32. Увс аймагт хүлээлгэн өгсөн дахивар хаягдал бутлах, пресслэх төхөөрөмж

7.2.6 УБ ХОТ РУУ ТЭЭВЭРЛЭХ.

Бэлэн болсон дахивар хаягдлуудыг дотоодод боломжтой бол тодорхой хэмжээгээр дахин ашиглах, боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэн бусад хаягдлыг Увс-УБ чиглэлийн машинд ачиж УБ хотод шууд дахин боловсруулах үйлдвэрүүдэд буулгахаар гэрээлэн ачуулна. Ачих үед нийт жинг тэмдэглэн авч баримт үүлдэн машинд өгч явуулна.

Ачихдаа хавчдаг өөрөө ачигч төхөөрөмж нь илүү тохиромжтой.

УБ хот руу тээвэрлэлт хийх асуудлыг томоохон ачаа тээврийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх боломжтой. Тэдгээр ачаа тээврийн байгууллагууд УБ руу буцахдаа ихэнх тохиолдолд хоосон буцдаг тул тээврийн зардал бага байх нөхцөл бүрдүүлэх боломжтой



7.2.7 ДАХИВРЫН БҮРТГЭЛ.

Улаангом сумаас ачигдан гарч байгаа бүх дахивар хаягдлын хэмжээг санхүүгийн бүртгэлд нэг бүрчлэн бүртгэн авч байна.

Шаардлагатай үед мэдээлэл шалгах, тулгах, статистик мэдээлэл авах нэн чухал шаардлагатай анхдагч мэдээлэл юм.

Хаягдлын мэдээллээс хэр хэмжээний хаягдлууд ирж буусан, дахиврын мэдээллээс хэр хэмжээний хаягдал дахивар болон дахин боловсруулалтад орж байгаа зэрэг тайлан мэдээг тогтмол болон шаардлагатай үед гаргаж байна.



7.2.8 ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРҮҮД.

Түншлэл нь дахивар хаягдлын дараах үйлдвэрүүдтэй ажилладаг.


- Хуванцар, гялгар уут – МОГ ПЛАСТИК ХХК
- Цаас – Сайн цаас ХХК (Бор картон цаас), Түмэн шувуут ХХК (Бусад цаас)
- Лааз - МОГ ПЛАСТИК ХХК
- Төмөр – ХАНГАЙН ГАНЭРДЭНЭ ХХК
- Хаягдал ажилласан тос – АЛТАН ОРШИХУЙ ХХК
- Гал тогооны хаягдал тос – ГАН-ЭКО МОНГОЛ ХХК

7.3 ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГ

Улаангом сумын төвлөрсөн хотын цэгийн сайжруулах, шүүрэл хөрсний нэвчилтээс хамгаалсан үе давхаргатай зориулалтын ланфилл талбай бэлдэх шаардлагатай байгаа.

Энэхүү ажил нь хөрөнгө мөнгө, цаг хугацаа их шаардагдах тул богино хугацаанд одоогийн талбайд зайлшгүй хэрэгжүүлэх Төвлөрсөн хогийн цэгийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр гүйцэтгэх ажлуудыг ач холбогдлын зэрэглэл, гүйцэтгэвэл зохих дарааллыг баримтлан дараах байдлаар төлөвлөв.

1. Төвлөрсөн цэгийн хилийг тогтоон, хуримтлагдсан хогоор далан барьж шороогоор хучиж ургамалжуулах.
2. Төвлөрсөн цэгт орон гарах замыг салгаж, орон замд автопүү байрлуулан орж байгаа бүх хаягдлын хэмжээг тэмдэглэж авч байх.
3. УБ хотын нэгдсэн хогийн цэгүүдэд хэрэгжүүлж байгаа автомат пүүлэх, бүртгэх системийг нэвтрүүлэх. Энэ нь тээврийн хэрэгслийн дугаарыг таньж, автопүүний жинтэй хамт бүртгэлийг хийдэг систем байгаа.




Энэ системийн тусламжтайгаар дураараа хог буулгах байдлыг хязгаарлах боломжтой.

4. Зөвхөн далангаар хүрээлэгдсэн талбайд хог буулгах чиглэлийг тээвэрлэгч байгууллагад өгөх.
5. Тогтоосон хугацаанд хүнд механизмыг ажиллуулж, талбайд хаягдсан хогийг түрж, нягтруулж байх.
6. Сард 1 удаагийн давтамжаар нягтруулсан хогийг хөрсөөр дарж булах зэрэг юм. Нэгдүгээр даланг хэт урт далан барилгүй, 2-3 жилд тээвэрлэгдэн ирэх хогийг дарж булах хэмжээтэй баривал зохино. Улмаар нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай тохиолдолд уг даланг өргөжүүлж болно.

7.3.1 ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Улаангом хотын төвлөрсөн хогийн цэг нь тэгш газар байршсан тул дараах зурагт үзүүлсний дагуу төлөвлөв. Төлөвлөлтийг хог хаягдлын нэгдсэн цэгийн төлөвлөлтийн хэсгээс дэлгэрэнгүй харна уу.



Зураг 33 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн ерөнхий байдал.

7.4 ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ НЬ

7.4.1 ХАЯГДАЛ ЦААС

Хаягдал цаасыг ялган ангилах, цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг ДАХИН БОЛОВСРУУЛАХ ХОГ ХАЯГДАЛ -ийг хэрхэн зохион байгуулах хэсэгт тусгагдсан. Цаасан хаягдал нэг төрлийн дахивар хаягдал юм. Цугларсан цаасан хаягдлыг дараах аргуудаар устгана.

1. Бордооны талбайд ажлын гүйцэтгэлд нийлүүлэх
2. Дахин боловсруулах. Шахмал түлш хийх үйлдвэрлэл хийх боломжтой.
3. Хаягдал цаасыг усанд дэвтээж байгаад шахаж цаасан шахмал түлш хийнэ. Түүнийг орон нутгийн зах зээлд нийлүүлэх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг ТЭЗҮ хэсгээс харна уу.
4. Дахин боловсруулах, ашиглах боломжгүй болсон хаягдлыг булах эсвэл дулааны боловсруулалтаар устгана.

7.4.2 ХООЛ ХҮНСНИЙ ХАЯГДАЛ

Компост буюу багсармал бордоо бэлтгэх гэдэг нь амьтны ба ургамлын гаралтай органик материалыг овоолог хийж эсвэл нүхэнд хийж ялзмаг хэлбэрт шилжүүлэн боловсруулах процесс юм.

7.4.2.1 ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛ

Гал тогооноос гарч буй био хог хаягдал, малын бууц, сүрэл, хонь ямааны хоргол, тахиа гахайн аж ахуйн хаягдал, үхрийн баас, түүхий мяндас, олсны ургамал, модны үртэс, будаа болон улаан буудайн хальс, ургамлын иш, сүү цагаан идээний хаягдал, мал нядалгааны газрын хаягдал, төмс, лууван, хүнсний ногооны ялзарсан үлдэгдэл, хоолны шавхруу, яс, төрөл бүрийн шаар, нийтийн хоолны газрын хаягдал, цэцэрлэгжүүлэлтийн үлдэгдэл (хугарсан мөчир, хатсан навч, холтос), хог ургамал, шарилж гэх мэт органик (био) гаралтай бүхий л түүхий эдийг ашиглан компост бордоог хийж болно. Түүхий эдийн мэдээллийг нэгтгэн судалж, түүхий эдийн дотор агуулагдаж буй нүүрстөрөгч азотын харьцааг зааварт заасны дагуу тохируулан хольж микро-организмуудын амьдрах нөхцөлийг буй болгох нь технологийн гол үндэс болох юм.

Компост бордооны үйлдвэрлэлийн явцад маш ихэд хэрэглэгддэг хэсэг нь бүтэц үүсгэх эх материалууд юм. Үүнд яс, иш мөчир зэрэг багтана. Бордоо бэлэн болсны дараа энэхүү материалыг том оврын шигшүүрээр шигшин авч эргүүлж ашиглах боломжтой.

Бэлэн болсон бүтээгдхүүнийг хөрс сайжруулах талбайг бордох зорилгоор ашиглахдаа тухайн хөрсний үржил шимээс хамааран бордох тунг тогтооно.



7.4.2.2 КОМПОСТ ҮЙЛДВЭРЛЭХ ЯВЦ

Компост үйлдвэрлэх явцыг 4 үе шатад хуваана:

Мезофил I үе шат	Эх материалуудыг хольж талбайд тавьж эхлэхээс энэ үе шат эхэлнэ. Цөөхөн хоногийн (2-8) дотор температур 45оС -т хүрнэ. Эрдэсжих процесс нэлээд явагдан рН 4.0 – 4.5 болно. Энэ нь органик хүчил үүсдэгтэй холбоотой.
Термофил үе шат	Энэ үе шатанд температурыг 60 оС-д хүргэнэ. Өвчин үүсгэгч микро организмууд энэ үе шатанд устгах ба үргэлжлэх хугацаа доод тал нь 6-10 хоног байна.
Мезофил II үе шат	Температурыг 40оС-аас дээш хэтрүүлж болохгүй ба рН нь сул шүлтлэг болсон байх ёстой.
Компост боловсрох үе	Энэ үе шат нь нэлээд удаан буюу хэдэн сарын турш үргэлжилдэг. Гумины болон фулво хүчлүүдийн полимеризацийн процесс энэ үе шатанд явагдана

Компостын материал, хийх хэмжээнээс хамааруулж технологийн гүйцэтгэл, дамжлагаас хамааруулж дараах 4 төрөлд хуваадаг.

1. МАА-н гаралтай хаягдал, өтөг, бууц, малын баас газар тариалангийн хаягдал, өвс тэжээлийн үлдэгдэл зэргийг ашиглан ах хэмжээгээр ашиглан масс үйлдвэрлэл явуулахад задгай урт эгнээ үүсгэж үйлдвэрлэл явуулах
2. Задгай талбайд болон байшинд хийхдээ ялзмагжуулах материалын доогуур нүхтэй хоолойнуудыг байрлуулдаг ба энэ нүхнүүдээр агаар өгдөг.
3. Вермикомпостын арга нь ялзрамхай хог хаягдлуудыг шим тэжээлээр баялаг бордоо болгон хувиргахдаа чийгийн улаан хорхойг ашиглах
4. Дотроо холигч, бутлагчийн үүргийг давхар гүйцэтгэх төхөөрөмж бүхий саванд ресторан болон томоохон гал тогоонуудын хоолны үлдэгдэл болон ялзрамхай хог хаягдлыг бордоо болгон ашиглах

7.4.3 ХАЯГДАЛ МОД/WOOD WASTE

Орон сууц, гэр хороолол болон бусад байгууллагуудаас үүсэж байгаа мод болон модон хаягдлыг ДХТөв дэх модон хаягдал буулгах цэгт татан төвлөрүүлнэ.

Ирж бууж байгаа модон хаягдлын хэмжээ бүртгэн авч дахин ашиглах боломжтой, боломжгүйгээр нь ялган ангилж дахин ашиглалтад нийлүүлэх ажиллагааг зохион байгуулна.


Ашиглах боломжгүй болсон модон хаягдлыг дулааны аргааг эсвэл булшилж устгана.

Химийн бодисын үлдэгдэлтэй эсвэл аюултай хаягдлын агууламжтай хаягдлыг технологийн горимын дагуу хадгалах устгах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

7.4.4 АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ХҮЛЭЭЖ АВАХ ЦЭГ

Хог хаягдлын тухай хуульд зааснаар “аюултай хог хаягдал” гэдэг нь тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдал юм. Энэ нь аюултай хаягдлыг шинж чанараар нь ангилж буй хэрэг юм.

Эдгээр аюултай ангилалд багтаж буй хог хаягдлыг энгийн хог хаягдалтай нийлүүлэн хаях нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд шууд, шууд бус замаар аюул учруулах нь элбэг. Иймд зориулалтын цэг байгуулж үүсэж буй аюултай хог хаягдлуудыг бүртгэлжүүлж байх шаардлагатай. Улмаар боловсруулах боломжтой аюултай хог хаягдлуудыг боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж, бусад хаягдлыг байгаль орчин сөрөг нөлөөлөл багтай байдлаар устгах шаардлагатай.



7.4.5 ЭМНЭЛГИЙН ХОГ ХАЯГДАЛ

Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлэг, амбулатори, лаборатори, цусны төв, шүдний эмнэлэг, мал эмнэлэг, амаржих газрууд болон энэ чиглэлээр судалгаа, сургалт үйлдвэрлэл, хяналтын ажил эрхэлдэг байгууллагуудад үүсэх хий, шингэн, хатуу хог хаягдлыг эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал гэнэ.

Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын ихэнх хэсэг нь буюу 75-90% нь энгийн хаягдал-картон цаас, хоолны үлдэгдэл зэрэг байдаг. Харин 10-25% нь аюултай хог хаягдал буюу өвчний нян бактер агуулсан цус биеийн шингэн, ашигласан зүү, хурц үзүүртэй зүсдэг материалууд, химийн бодис агуулдаг шархны лент, шархны боодол, чандарлах газрын үнс гэх мэт хог хаягдал байдаг.

Хогийг хадгалж тээвэрлэх:

Эрүүл мэндийн байгууллагууд хог хаягдлыг хогийн цэг рүү хүргэх хүртлээ маш болгоомжтой байх ёстой. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлуудад тэр орчинд нь халдваргүйтгэл хийх ёстой.

- Эмнэлгийн хортой буюу халдвартай хогийн савыг коридор, угаалгын өрөө болон өөр хогтой холилдож болохуйц газар тавьж болохгүй.
- Хогийн сав болон хогны уутыг 4-ний 3 хүртэл хэмжээнд дүүрэхэд нь дарж битүүлж байх хэрэгтэй.
- Ашигласан зүү болон хурц үзүүртэй хогийг хэзээ ч гялгар ууттай хогонд хийж болохгүй, тусгай картон цаасанд хийнэ.

Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг хадгалах түр хадгалах байр нь:

- Гаднын хүн орохооргүй, нийтийн хөл хөдөлгөөнөөс зайтай газарт байрлаж шувуу, амьтан орох боломжгүй, цоожтой байх
- Шал ус нэвтрүүлэхгүй хатуу хучилттай байх
- Нарны гэрэл шууд тусахааргүй, сэрүүн (18 градусаас ихгүй 60%-ийн чииглэг) , агааржуулалт сайтай
- Хог хаягдлыг төрөлжүүлэн хадгалах боломжтой
- Жин 0,1-120кг
- Хана нь 2 метрээс доошгүй өгдөртэй байх
- Шал нь бохир ус цуглуулах сувагт холбогдсон байх
- Цахилгаан, цэвэр бохир усны төв шугамд холбогдсон байх
- Хөдөө орон нутаг халдвартай хог хаягдлыг халдваргүйтгэх хэсэгтэй байх
- Халдваргүйтгэх хэсэг нь агааржуулалтын системтэй байх
- Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зам талбайтай байх шаардлагатай

Эмнэлэгийн хог хаягдлыг ангилан ялгах болон халдваргүйтгэл хийлгэж хаяснаар түүнээс гарах эрсдлийг бууруулж чадна. Хамгийн эрүүл халдваргүйтлийн арга нь хлорин, цайруулагч пироксид буу химийн бодис ашиглах, буцалгах, ууранд халаах, даралттай ууранд халаах, микропеч болон автоклер зууханд халдваргүйтгэл хийх арга юм.

Халдваргүйтгэх аргуудаас дурдвал:

- Химийн бодисоор халдваргүйтгэх
- Хлорын шохой ашиглан халдваргүйтгэх
- Шохойн хувин ашиглан халдваргүйтгэх
- Угаалга хийх
- Дулаанаар халдваргүйтгэх
- Буцалгаж халдваргүйтгэх
- Ууранд ариутгах
- Даралтат уурын саванд ариутгах
- Халуун хуурай агаар ашиглан халдваргүйтгэх
- Чийгтэй агаар ашиглан халдваргүйтгэх
- Туяагаар халдваргүйтгэх
- Өндөр давтамжит дуу авиагаар халдваргүйтгэх зэрэг маш олон арга байдаг.

Одоогийн байдлаар эрүүл мэндийн хог хаягдлыг устган зайлуулахад эрүүл ахуйн хяналттай ландфил буюу хяналттай дарж булах технологийг ашиглах нь тохиромжтой гэж үздэг.

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагууд 2014 оны эрүүл мэндийн сайдын 186, 187-р тушаалаар батлагдсан халдварын хяналт сэргийлэлтийн чиглэлээр баримтлах журам, заавар, олон улсын стандартыг мөрдөн ажиллаж байна.

АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

Эмнэлгээс гарах хог хаягдлыг ууран ариутгалын технологи ашиглан халдваргүйжүүлж устгана. Эмнэлгийн хаягдлыг хүлээн авч устгалд оруулах хүртэл бүхий үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага хариуцаж ажиллана.

- Эмнэлгээс хаягдал хүлээж авах үйлчилгээ үзүүлэх.
- Эмнэлгийн хаягдлыг ууран ариутгал (autoclave) хийх хүртэл ДХТ дээр тусгай зориулалтын орчинд хадгална
- Хаягдлыг ууран ариутгалд бэлдэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Эмнэлгийн хаягдлыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор ууран ариутгалд оруулж халдваргүйжүүлнэ

7.4.6 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАН/RECORD KEEPING

Улаангом сумын хөгжлийн бодлогод нийцэж ажиллах болон тухайн сард гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээг нарийвчлан тооцох зорилгоор дараах ажлуудын бүртгэлийг гүйцэтгэнэ.

7.4.6.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА

- ⊕ Өрхүүд болон ААН бүрээс ирсэн ачилтын тоо, хог хаягдлын хэмжээг бүртгэж тогтмол сар, улирал, жилээр багцлан тайлагнан архивлах;
- ⊕ Дахин боловсруулах хог хаягдлын хэмжээг бүртгэж тогтмол сар, улирал, жилээр багцлан тайлагнан архивлах;
- ⊕ Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны чанарыг үргэлж сайжруулах зорилгоор тодорхой давтамжтайгаар тоо мэдээлэл цуглуулж анализ хийх нь үндсэн ажлын чухал хэсэг байна.

7.4.6.2 ХҮНИЙ НӨӨЦ БА ЧАДАМЖ

Яг одоогийн нөхцөл байдал дээр Улаангом сумын хог хаягдлын менежментэд тулгамдаж буй асуудлын нэг нь зайлшгүй хог хаягдлын бүртгэл мэдээлэл, тайлан юм. Иймд үүнд зориулан ажлын байр бий болгож хогийн цэг дээр хог тээвэрлэн орж буй машин бүрийг жинлэх жинлүүр, бүргэл хөтлөх ажилтны байр зэргийг хогийн цэг дээр бий болгох зайлшгүй шаардлагатай.

